



УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗАР

# УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Улаангом сум  
2025 он

## ГАРЧИГ

### УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ТАЙЛАН

#### НЭГ. УДИРТГАЛ

1.1 Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн жил хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн тэргүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт.

#### ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Дүн шинжилгээ

2.2. Шүүхийн хүний нөөцөөр хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Дүн шинжилгээ

2.3. Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Дүн шинжилгээ

2.4. Шүүхийн санхүү эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Дүн шинжилгээ

2.5. Мэдээллээр хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Дүн шинжилгээ

**ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ**

## НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.2-т “Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Тамгын газар үйл ажиллагаагаа Ерөнхий зөвлөлд тайлагнана”, гэж заасны дагуу Увс аймаг дахь шүүхийн тамгын газар нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан дүрэм журмууд, бодлого шийдвэр, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тус шүүхийн тамгын газрын даргаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн талаарх тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 33 дугаар тогтоолоор баталсан “Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааг үнэлэх журам”-д заасан бүтэц, загварын дагуу тайлагналаа.

Увс аймаг дахь шүүхийн Тамгын газар нь 2025 онд 2,982,500,000 төгрөгийн төсөвтэй, нийт 9 шүүгч, захиргаа, үйлчилгээний 28, нийт 37 хүний орон тоотой ажиллалаа.

Тус шүүхийн тамгын газрын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 чиглэлээр 76 арга хэмжээ тусгагдсанаас 73 арга хэмжээ биелэгдэж төлөвлөгөөний хэрэгжилт 96 хувьтай байна.

Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах, шүүх, шүүхийн захиргааны үйл ажиллагааг хуульд заасан хугацаанд хэвийн тасралтгүй үргэлжлүүлэх зохион байгуулалтыг хийж Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн үйл ажиллагааны бэлэн байдал хангаж, хууль хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.

Түүнчлэн, шүүхийн тамгын газраас 2025 онд хэргийн хөдөлгөөний хяналт, хүний нөөцийг чадваржуулах, шүүгч ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, шүүхийн үйл ажиллагааг нээлттэй сурталчлах чиглэлийн зорилт тавин ажиллав.

Энэ хүрээнд хэргийн хөдөлгөөний чиглэлээр 7 хоног бүр хяналт шалгалт хийж, мэдээлэл бэлтгэн хамт олны шуурхай зөвлөгөөнд танилцуулж хэвшсэн ба 2025 оны хэргийн хөдөлгөөний удирдлагын цахим хяналт-шинжилгээгээр I улиралд 93.7, II улиралд 95.4, III дугаар улиралд 94.2 хувьтай буюу “**Бүрэн хангалттай**” үнэлгээ авсан.

Мөн хүний нөөцийг чадавхжуулах зорилтын хүрээнд Шүүхийн тамгын газрын “Сургалт, судалгааны хороо”-оос 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 чиглэлийн хүрээнд 13 ажил зохион байгуулахаар төлөвлөж, 7 хоног бүрийн 5 дахь өдрийн 16:00 цагийг шүүхийн захиргааны ажилтнуудын хөгжлийг дэмжих зорилгоор сургалтын цагийг бий болгосон. Тус сургалтын хүрээнд мэдээлэл технологийн чиглэлээр 4, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 3, эрүү, иргэн захиргааны эрх зүйн бодлого бодох аргачлалын хүрээнд 4,

ХАСХОМ гаргахад анхаарах асуудлын талаар 1, шүүхийн захиргааны ажилтны чөлөөт, бүтээлч, бие даасан сэтгэлгээтэй, сурах, ажиллах, амьдрах арга барил олгох зорилгоор 4 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллээр хангах чиглэсэн арга хэмжээний хүрээнд болон тамгын газрын зүгээс нээлттэй хаалганы өдөрлөг 2 удаа, мөн Өлгий, Өмнөговь, Ховд, Бөхмөрөн, Завхан Наранбулаг сум болон Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, 3 дугаар сургууль, 4 дүгээр сургуулиудад шүүхийн үйл ажиллагаа, шүүгчийн ажлын онцлогийн талаарх сургалт, Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн сурагчдад “Цахим орчны зохистой хэрэглээ” сэдвээр сургалт, ярилцлагыг тус тус зохион байгууллаа.

Шүүгч, ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад зориулж 10 ширхэг суурин компьютер, Ерөнхий шүүгч, шүүгч нар болон тамгын газрын дарга, шүүхийн захиргааны ажилтнуудын тавилгыг бүрэн шинэчилсэн.

2025 онд шүүгч, ажилтнуудын ажиллах орчин болон иргэд шүүхийн үйлчилгээг ая тухтай орчинд хүргэх зорилгоор шүүхийн байрны 1-3 давхарт их засвар хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд шүүхийн үйлчилгээний болон шүүх хуралдааны танхим, зарим шүүгч, ажилтны өрөөнд засвар хийгдсэн ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тусгай зориулалтын 00-ын өрөө тохижуулсан.

Мөн шүүхийн тамгын газар нь өөрсдийн дотоод нөөцийг ашиглан “шүүх хуралдааны 3 дугаар танхим”, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны хөгжлийг дэмжих зорилгоор “сургалтын танхим”-ыг тус тус шинээр бий болгов.

Батлагдсан төсвийг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн шуудан, харилцаа холбооны зардал, бичиг хэргийн зардал, тээврийн хэрэгслийн болон бусад зардлыг үр ашигтай зарцуулж, өр, авлага үүсгэлгүй ажиллалаа.

УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

ХОЁР ҮНДСЭН ХЭСЭГ

**2.1. ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

**2.1.1. Шүүхийн тамгын газар хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ.**


2.1.1.1. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор баталсан “Эрүү, Иргэн, Захиргааны хэрэг, Зөрчлийн хэрэг маргааны хянан шийдвэрлэх, шүүх хуралдааны даргалагчийн дарааллыг тогтоох, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч болон шүүх бүрэлдэхүүнийг томилох, дарааллыг тогтоох, шүүхэд өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчид хуваарилах журам”-ын дагуу хэргийн хөдөлгөөний бүртгэл хяналтын нэгдсэн системд тохируулж хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг шүүгч нарт хуваариллаа.

**ХЭРЭГ ХУВААРИЛАХ НАРИЙВЧИЛСАН ЖУРМЫН БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН НЭГДСЭН СИСТЕМД ТОХИРУУЛСАН БАЙДАЛ**

Эрүү, Иргэн, Захиргааны хэрэг, Зөрчлийн хэрэг маргааны хянан шийдвэрлэх, шүүх хуралдааны даргалагчийн дарааллыг тогтоох, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч болон шүүх бүрэлдэхүүнийг томилох, дарааллыг тогтоох, шүүхэд өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчид хуваарилах журам

|  |   |  |   |
|--|---|--|---|
| <p><b>01</b></p>  <p>УВС АЙМГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ</p> <p>2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 2024/ШЗТ/01 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоол</p> <p><a href="http://www.court.uv.gov.mn">www.court.uv.gov.mn</a></p> | <p><b>02</b></p>  <p>УВС АЙМАГ ДАХЬ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ</p> <p>2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 124/ЗТ2025/0001 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоол</p> <p><a href="http://www.facebook.com/uvscourts">www.facebook.com/uvscourts</a></p> | <p><b>03</b></p>  <p>УВС АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН АНХАН ШАТНЫ ШҮҮХ /Эрүү/</p> <p>2025 оны 07 дугаар сарын 03-ний өдрийн 2025/ШЗТ/26 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоол</p> | <p><b>04</b></p>  <p>УВС АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН АНХАН ШАТНЫ ШҮҮХ /Иргэн/</p> <p>2025 оны 07 дугаар сарын 03-ний өдрийн 318/ЗТ2025/00038 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоол</p> <p>Утас: 7045-4570</p> |
|--|---|--|---|

2.1.1.2 Дээрх журмуудын дагуу хэргийн хөдөлгөөний бүртгэл хяналтын нэгдсэн системээр Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар өмнө оны хүлээн авч хянан шийдвэрлэсэн хэргээс эрүүгийн хэрэг 66 буюу 34.8 хувиар өссөн, зөрчлийн хэрэг 93 буюу 66.6 хувиар өссөн, иргэний хэрэг 42 буюу 14.2 хувиар өссөн нийт 201 өмнөх оноос 38.5 хувиар өссөн дүнтэйгээр хүлээж авч бүртгэлээр шүүгчид шилжүүлжээ.



ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠤᠪᠤᠰᠤ ᠤᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠰᠢᠭᠡᠬᠡᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷᠢᠨ ᠦᠯᠤᠰ ᠠᠵᠢᠯᠢᠭᠠᠨᠢ ᠲᠠᠢᠯᠠᠭᠤᠨ




Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2025 оны 11 сарын 24-ний өдрийн байдлаар өмнөх оны хянан шийдвэрлэсэн хэргээс нэхэмжлэл 63 буюу 1.58 хувиар буурсан дүнтэй байна.

Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан гомдол 7, давж заалдах журмаар гаргасан гомдол 13, хяналтын журмаар гаргасан гомдол 7, хүчингүй болсон хэргийг дахин хуваарилсан 3, бусад хүсэлт 7 нийт 100 өмнөх оноос 4.8 хувиар өссөн дүнтэйгээр хэргийн хөдөлгөөний нэгдсэн системээр хүлээн авч шүүгчид бүртгэлээр шилжүүлжээ.

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн иргэний хэрэг 2025 оны 11 сарын 24-ний өдрийн байдлаар өмнөх оноос нэхэмжлэл 1328 буюу өмнөх оноос 41.8 хувиар өссөн, сөрөг нэхэмжлэл 10, /ГШБ/ хүсэлт 212, 170-н гомдол 9, давж заалдах журмаар гаргасан гомдол 30, хяналтын журмаар гаргасан гомдол 11, адил шатны шүүхээс даалгавар гүйцэтгүүлэхээр ирүүлсэн хүсэлт 32, эвлэрүүлэн зуучлагчаас эвлэрлийн гэрээг баталгаажуулахаар 69 шилжүүлсэн материал нийт 1701 өмнөх оноос 48.8 хувиар өссөн дүнтэй хэргийн хөдөлгөөний бүртгэл хяналтын нэгдсэн системээр хүлээн авч, адилтгах бүртгэлээр шүүгчид шилжүүлэн өгсөн байна.


Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд 2025 оны 11 сарын 24-ний өдрийн байдлаар өмнөх оны шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 273 буюу өмнөх оноос 1.09 хувиар буурсан, зөрчлийн хэрэг 915 буюу өмнөх оноос 125.1 хувиар буурсан дүнтэй байна. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хэрэг 8, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүсэлт 37, давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцэл 54, хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцэл 11, ТСАХ 23, албадлагын арга хэмжээ авхуулах санал 206 нийт 1527 өмнөх оноос 73.7 хувиар буурсан дүнтэй хүлээн авч, хэргийн хөдөлгөөний бүртгэл хяналтын нэгдсэн системээр хуваарилан шүүгч, шүүгчийн туслах нарт шилжүүлэн өгч бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зуруулж баталгаажууллаа.

Анхан болон давж заалдах шатны шүүхэд хүлээн авсан хэрэг, нэхэмжлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:






МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 19 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 19.2.5-Т ЗААСНЫ ДАГУУ ӨӨРИЙН НАРИЙВЧИЛСАН ЖУРМЫГ БАТЛАН МӨРДӨЖ АЖИЛЛАЖ БАЙГАА БӨГӨӨД ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНӨӨС БАТАЛСАН НАРИЙВЧИЛСАН ЖУРМЫГ МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН МЭРГЭЖИЛТЭН ТОХИРУУЛАХДАА ШҮҮХИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА БОЛОН ТУХАЙН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН ТУСЛАХЫГ БАЙЛЦУУЛАН ЭНЭ ТАЛААР ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДЭЖ, ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ СИСТЕМД ХИЙСЭН АЖИЛЛАГАА БҮРИЙГ ДЭЛГЭГИЙН БИЧЛЭГЭЭР ХАДГАЛЖ БАРИМТЖУУЛЖ, ТАМГЫН ГАЗРЫН ДАРГАД ТАНИЛЦУУЛЖ БАЙНА. ЭНЭХҮҮ ЖУРМЫГ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 19 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 19.4 ДЭХ ХЭСЭГТ ЗААСНААР ШҮҮХИЙН ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛЖ ИРГЭД ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЖ АЖИЛЛАЛАА.




2.1.1.3 Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2024 оны 205, 218, 229 дугаар тогтоолоор баталсан Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал, шүүхэд албан хэрэг хөтлөх журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.



Шүүх тус бүр “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журамд нийцүүлэн, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5-т заасны дагуу өөрийн нарийвчилсан журмыг батлан мөрдөж ажиллаж байгаа бөгөөд шүүгчдийн зөвлөгөөнөөс баталсан нарийвчилсан журмыг мэдээлэл технологийн мэргэжилтэн тохируулахдаа шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн дарга болон тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн туслахыг байлцуулан энэ талаар тэмдэглэл үйлдэж, хэргийн хөдөлгөөний системд хийсэн ажиллагаа бүрийг дэлгэцийн бичлэгээр хадгалж баримтжуулж, тамгын газрын даргад танилцуулж байна. Энэхүү журмыг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт зааснаар шүүхийн цахим хуудсанд байршуулж иргэд олон нийтэд мэдээлж ажиллалаа.


2.1.1.4 Нарийвчилсан журамд заасны дагуу “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох” программын ажиллагаа, программ дээр хийгдсэн үйлдэл бүрийг дүрс бичлэг /screen recording/ хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид хуулбарлан хадгалж тамгын газрын дарга хяналт тавин ажиллаж байна.



2.1.1.5 Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд:

Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 66 эрүүгийн хэрэг, 42 иргэний хэрэг, 93 зөрчлийн хэрэг бүртгэл хяналтын нэгдсэн системээс хүлээн авч эрүүгийн хэргийн шүүгчийн захирамж 64, ерөнхий шүүгчийн захирамж 401, эрүүгийн хэргийн магадлал 63, зөрчлийн хэргийн магадлал 89, зөрчлийн шүүгчийн захирамж 86, шүүхийн тогтоол 14, зөвлөгөөний тогтоол 1, шүүх хуралдааны тэмдэглэл 74, иргэний хэргийн шүүгчийн захирамж 55, шүүхийн тогтоол 15, магадлал 32, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол 27, ерөнхий шүүгчийн захирамж 74, шүүх хуралдааны тэмдэглэл 42 буюу нийт 1238, өмнөх оноос 101 хувиар өссөн дүнтэй эрх зүйн актын дугаарыг авч баталгаажуулжээ.




Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд:

Увс аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 63 нэхэмжлэлийг захиргааны бүртгэл хяналтын нэгдсэн системээр хүлээн авч шийдвэр 44, шүүгчийн захирамж 255, шүүхийн тогтоол 2, мэдэгдэх хуудас 6, гүйцэтгэх хуудас 25, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол 39, ерөнхий шүүгчийн захирамж 45, албан бичиг 171 буюу нийт 587 өмнөх оноос 10.06 хувиар өссөн дүнтэй эрх зүйн актын дугаарыг авч баталгаажуулжээ.




Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд:

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 272 эрүүгийн хэрэг, 915 зөрчлийн хэргийг эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системээр хүлээн авч шүүгчийн захирамж /ТСАХ/ 23, шүүхийн тогтоол-36, шүүгчийн захирамж /эрүүгийн хэрэгт/ 594, шүүгчийн захирамж /зөрчлийн хэрэгт/ 1011, Ерөнхий шүүгчийн захирамж 1326, шийтгэх цагаатгах тогтоол 253, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол 32, шийтгэвэр 917, шүүх хуралдааны тэмдэглэл 327, шүүгчийн захирамж /хянан магадлан/ 8, гүйцэтгэх хуудас /эрүүгийн хэрэг/ 293, гүйцэтгэх хуудас /зөрчлийн хэрэг/ 612, нийт 6583 өмнөх оноос 52.8 хувиар өссөн дүнтэй эрх зүйн актын дугаарыг авч баталгаажуулжээ.



**ИРГЭН-2014 бүртгэл хяналтын нэгдсэн системд:**

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 1339 нэхэмжлэлийг иргэний хэргийн бүртгэл хяналтын “ИРГЭН-2014” системээр хүлээн авч шийдвэр 1057, шүүгчийн захирамж 2814, шүүхийн тогтоол 70, гүйцэтгэх хуудас 296, ерөнхий шүүгчийн захирамж 2097, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол 131, албан бичиг 881 буюу нийт 7346 өмнөх оноос 73.7 хувиар өссөн дүнтэй эрх зүйн актын дугаар авч баталгаажуулжээ.




2.1.1.6 Шүүн таслах ажиллагааны статистик мэдээ, тайланг 1,2,3-р улирлын байдлаар нэгтгэн гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээллийн технологийн газрын Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэст цахим болон шуудангаар заасан хугацаанд хүргүүлсэн байна.

2.1.1.7 Увс аймгийн анхан болон давж заалдах шатны шүүх, Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд бүртгэл хяналтын нэгдсэн системээс хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, хүлээн авч шүүгчид шилжүүлсэн судалгааг сар тутамд гаргаж Ерөнхий шүүгч, шүүгч нарт танилцуулан мэдээллийг хүргүүлж байна.

2.1.1.8 Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 82 дугаар тогтоолоор баталсан “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам”-ын дагуу шүүх хуралдаанд цахимаар оролцох тухай хүсэлт ирүүлсэн иргэдэд тус журамтай танилцсан болон шүүх хуралдааны дэгийг сахиж оролцох тухай цахим оролцогчийн баталгааг гаргуулан авч хэрэгт хавсаргаж байна.

2025 оны 11 сарын 24-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор Увс аймгийн эрүү, иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нийт **2304** шүүх хуралдаан явагдсанаас **294** шүүх хуралдаанд **399** хүн цахимаар оролцсон нь нийт шүүх хуралдааны **12.7** хувийг эзэлж байна.



### 2.1.2 Хэргийн хөдөлгөөний цахим хяналт шалгалтын хүрээнд:

2.1.2.1 Тус шүүхийн тамгын газар нь хэргийн хөдөлгөөний чиглэлээр 7 хоног бүр хяналт шалгалт хийж мэдээлэл бэлтгэн хамт олны шуурхай ярианд танилцуулж хэвшсэн ба 2025 оны хэргийн хөдөлгөөний удирдлагын I, II, III дугаар улирлын цахим хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 93.7, 95.4, 94.2 оноо буюу “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан.



Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 158 дугаар тогтоолоор батлагдсан “Хэргийн хөдөлгөөний хяналтын журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.1-т зааснаар дотоод хяналт шалгалтыг журмын 3.14-д заасан хугацаанд сар тутам хийж, дотоод хяналтын шалгалтын маягтын нэгтгэл, тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөний удирдлага, статистикийг газарт хүргүүлж байгаа бөгөөд хэргийн

хөдөлгөөний программын нэгдсэн сан бүрдүүлэлтийг цаг хугацаанд нь гүйцэтгэж, албан хэрэг хөтлөлтийн алдаа зөрчил гаргахгүй байх эерэг үзүүлэлттэй байна.

2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 1-10 сарын хэргийн хөдөлгөөний дотоод хяналт шалгалтыг хийж хүргүүлсэн байна.

Дотоод хяналт, шинжилгээ-үнэлгээг сар, улирал, хагас жилээр хийснээр алдаа зөрчлийг цаг тухай бүрд нь илрүүлж, залруулах, цаашид алдаа гаргахгүй байх талаар зөвлөн тусалж ажиллаж байна.

2.1.2.2 Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 102 дугаар тушаалаар баталсан “Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим систем live.shuukh.mn-д зааснаар live.shuukh.mn цахим системийн хөтлөлтийг шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хийдэг ба тамгын газраас тухай бүр хяналт тавин ажиллаж дараах байдлаар системд ажиллагаа хийсэн байна.



2.1.2.3 Увс аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн сарын хэргийн хөдөлгөөний мэдээг тухайн сарын ажлын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын ажлын эхний өдөр Эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалд заасны дагуу [www.case.shuukh.mn](http://www.case.shuukh.mn)-д байршуулж, мөн давж заалдах шатны шүүхийн хэргийн хөдөлгөөний сарын мэдээ, зөрчил болон таслан сэргийлэх арга хэмжээний мэдээний хамт ШЕЗ-ийн [ecase@shuukh.mn](mailto:ecase@shuukh.mn) хаяг руу явуулж байна.

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/

| № | Бүтэц                | Шүүхийн нэр   | Жил, сар        | Өгөөс               | Үйлдэл |
|---|----------------------|---|-----------------|---------------------|--------|
| 1 | Иргэний хэргийн шүүх | Увс аймгийн сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/ | 2025 он, 10 сар | 2025-10-31 15:10:04 | 🔍 🗑️   |
| 2 | Иргэний хэргийн шүүх | Увс аймгийн сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/ | 2025 он, 9 сар  | 2025-10-01 09:54:02 | 🔍 🗑️   |
| 3 | Иргэний хэргийн шүүх | Увс аймгийн сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/ | 2025 он, 8 сар  | 2025-09-29 18:00:44 | 🔍 🗑️   |
| 4 | Иргэний хэргийн шүүх | Увс аймгийн сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/ | 2025 он, 7 сар  | 2025-09-01 09:30:12 | 🔍 🗑️   |
| 5 | Иргэний хэргийн шүүх | Увс аймгийн сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/ | 2025 он, 6 сар  | 2025-07-01 12:01:06 | 🔍 🗑️   |
| 6 | Иргэний хэргийн шүүх | Увс аймгийн сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/ | 2025 он, 5 сар  | 2025-05-30 16:47:44 | 🔍 🗑️   |
| 7 | Иргэний хэргийн шүүх | Увс аймгийн сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/ | 2025 он, 4 сар  | 2025-05-01 20:32:49 | 🔍 🗑️   |
| 8 | Иргэний хэргийн шүүх | Увс аймгийн сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/ | 2025 он, 2 сар  | 2025-02-28 15:40:42 | 🔍 🗑️   |
| 9 | Иргэний хэргийн шүүх | Увс аймгийн сум дундын анхан шатны шүүх /Иргэний хэргийн/ | 2025 он, 1 сар  | 2025-01-31 17:21:52 | 🔍 🗑️   |

Шүүн таслах ажиллагааны статистик мэдээ, тайланг 1,2,3-р улирлын байдлаар нэгтгэн гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээллийн технологийн газрын Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэст цахим шуудангаар заасан хугацаанд хүргүүлсэн байна.

**2.1.3 Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах тухай журам”-ын хүрээнд хэрэгжүүлсэн ажил:**


2.1.3.1. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах тухай журам”-ын 4.1-д зааснаар эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэх /цагаатгах/ тогтоолуудыг байршуулж байна.

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Увс аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн эрүүгийн **54** магадлал, иргэний **32** магадлалыг, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн **42** шийдвэр, Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн эрүүгийн **208** шийтгэх тогтоол, иргэний **855** шийдвэрийг цахим санд байршуулсан.



Анхан болон давж заалдах шатны шүүх нь 2025 онд эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалд заасны дагуу иргэн, хуулийн этгээд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад нийт **1197** гүйцэтгэх хуудсыг хүргүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **180** буюу 07 хувиар буурсан дүнтэй байна.

2.1.3.2 Шүүхийн шийдвэрийн цахим хуудас /shuukh.mn/ дахь 2016-2024 оны хооронд байршуулсан анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүхийн шийдвэр, шийтгэх тогтоол, магадлалыг нягталж “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”-д заасан шаардлагад нийцүүлэн байршуулж илэрсэн зөрчлүүдийг арилгаж ажиллалаа.



2.1.3.3 Увс аймаг дахь анхан шатны шүүхийн шүүгчид 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгч нартай шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудасны биелэлтийн талаар уулзалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа.



Шийдвэр гүйцэтгэл уулзалт зөвлөгөөн

2.1.3.4 Увс аймаг дахь сум дундын анхан шүүхээр шийтгүүлсэн **256** хэргийн **304** иргэнд холбогдох, эрүүгийн хариуцлага хүлээсэн тухай тэмдэглэлийг жагсаалтын хамт Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны статистик мэдээллийн хэлтсийн хэлтсийн лавлагааны санд ажлын 5 хоногийн дотор шүүхийн тамгын газрын албан бичгээр хүргүүлж, эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний ял шийтгэлийн тэмдэглэл

| №  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
|----|---------|--------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| 1  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 2  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 3  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 4  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 5  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 6  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 7  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 8  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 9  | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 10 | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 11 | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 12 | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |
| 13 | Шийтгэл | Сүрьеэ | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл | Хүндэтгэл |


Зураг: Ял шийтгэлийн тэмдэглэл хүргүүлсэн байдал.

хүргүүлсэн тухай бүртгэлийн дэвтэрт мэдээллийг хөтөлж байна. Хугацаа хожимдуулж хүргүүлсэн тохиолдол байхгүй байна.

**2.1.4 Захиргааны удирдлагын хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ.**

2.1.4.1 Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хүрээнд:

Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн нэршил өөрчлөгдөж Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.



2.1.4.2 Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд тус шүүхийн тамгын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 100 дугаартай тушаалаар ажлын хэсэг байгуулан ажилласан. Тус ажлын хүрээнд Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хүлээн авсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа эрүүгийн 36 хэрэг, зөрчлийн 1 хэрэг, Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүлээн авсан 132 хэрэг, 3 нэхэмжлэлийг зөвлөгөөний тогтоолоор эрүү, иргэний хэргийн системээр дахин хуваарилах, хэргийг шүүгчид хүлээлцэх ажлыг алдаа зөрчилгүй зохион



байгуулж ажилласан.


2.1.4.3 Шүүхийн нэршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан шүүхийн хэвлэмэл хуудасны эхийг батлуулж, эрх бүхий байгууллагаар хэвлүүлэх ажлын хүрээнд Анхан болон давж заалдах шатны шүүх, шүүхийн Тамгын газарт ашиглагдах 37 нэр төрлийн хэвлэмэл хуудсыг Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан “Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага” MNS 5140-3:2021-д нийцүүлэн бэлтгэж, Архивын ерөнхий газраар батлуулсан.

2.1.4.4 Үндэсний бичгийн хэвлэмэл хуудасны загварыг Увс аймгийн Монгол хэлний бодлогын зөвлөлийн гишүүн, Монгол хэл, бичгийн багш Д.Баярхүүгээр хянуулан бэлтгэж, Увс аймгийн төрийн архивын Архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын байцаагчаар баталгаажуулсан.

Дээрх Увс аймгийн архивын тасгаар хэвлүүлэн 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

2.1.4.5 Шинэ хэвлэмэл хуудас ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан Зохион байгуулалтын хэлтсийн дарга Б.Доржсүрэн, Архив бичиг хэргийн эрхлэгч Б.Ариунтуяа, нярав С.Сүхбаяр нар хүчингүй болсон буюу Увс аймаг дахь сум дундын Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэвлэмэл хуудсыг шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны дарга нараас хураан авч нэгтгэн тооллого хийж эрүүгийн **2296**, иргэний **1749** ширхэг, нийт **4045** ширхэг хуучин хэвлэмэл хуудсыг устгасан.

Үүнд:





2.1.4.6 Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн тамга, тэмдгийг нэгдсэн журмаар шинээр хийлгэж ирүүлснийг хүлээн авч 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагаанд хэрэглэж эхэлсэн.

2.1.4.7 Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамга, тэмдэг болон баталгааны тэмдгийг тус шүүхийн тамгын газрын дарга Л.Баттулга 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дотоод ажил хариуцсан ахлах шинжээч Б.Золзаяад хүлээлгэн өгсөн.



Хуучин тамга тэмдэг хүлээлцсэн тухай

## 2.1.5 Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн талаар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байдал:

2.1.5.1 Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2025 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэдийн төлөөлөгчийн жишиг тоо"-нд үндэслэн Увс аймагт Захиргааны хэрэгт оролцох 1278 иргэн, Эрүү иргэний хэрэгт оролцох 1278 иргэний нэрсийг тус шүүхийн тамгын газарт 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 03/1701 тоот албан бичгээр ирүүлснийг хүлээн авч доорх арга хэмжээ зохион байгуулан ажиллалаа.

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газраас Шүүхийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2.3, 62.5 дахь хэсэгт заасан шаардлага хангасан иргэдийг иргэдийн төлөөлөгчөөр сонгохын тулд нутгийн захиргааны байгууллагатай хамтран нэрсийг нягтлах ажлын хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 345 дугаар албан бичгээр Увс аймгийн 19 сумын Засаг дарга болон Тамгын газар руу тус албан бичгийг сум бүрээр нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс

ирүүлсэн иргэдийн нэрсийг жагсаалтын хамт хүргүүлж, иргэдийн төлөөлөгчид тавигдах шаардлага хангаж байгаа эсэхийг ажилласан.

2.1.5.2 Увс аймгийн цагдаагийн газарт 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 334 тоот албан бичгийг хавсралт нэрсийн хамт илгээж тухайн иргэдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаар лавлагааг авч захиргааны хэрэгт оролцох иргэдийн төлөөлөгч 1278 иргэнээс хуулийн шаардлага хангаагүй иргэдийг хасаж 775 иргэнийг, Эрүү, иргэний хэргийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох 1278 иргэнээс хуулийн шаардлага хангаагүй иргэдийг хасаж 798 иргэнийг шүүхийн тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар 2026-2027 онд шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтыг баталлаа.

2.1.5.3 Тус иргэдийн төлөөлөгчдийн нэрсийг баталсан тушаалыг хавсралтын хамт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэн ажилласан болно.

2.1.5.4 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлыг иргэдэд ухуулан таниулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Увс аймгийн Өлгий, Өмнөговь суманд, 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Увс аймгийн Ховд, Бөхмөрөн суманд, 2025 оны 05 сарын 02-ны өдөр Увс аймгийн Завхан, Наранбулаг, Тэс, Зүүнговь зэрэг нийт 8 суманд албан томилолтоор ажиллаж шүүхийн иргэдийн төлөөлөгчийн мэдээллийн санд бүртгэгдсэн иргэдэд Шүүхийн иргэдийн төлөөлөгчид шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцохын ач холбогдол, нөлөөллийн мэдүүлгийг хэрхэн хөтлөх талаар холбогдох сургалт мэдээллийг өгч ажиллалаа.



Иргэдийн төлөөлөгчийн нэрс батлах тухай



Иргэдийн төлөөлөгчийн нэрс хүргүүлэх тухай



Зураг 1: Иргэдийн төлөөлөгчийн сургалт



Зураг 2: Иргэдийн төлөөлөгчийн сургалт

2.1.5.5 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар эрүүгийн хэргийн бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд **10**, иргэний хэргийн бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд **12**, захиргааны хэргийн бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд **4**, нийт 26 Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 63.2-т зааснаар шүүх хуралдааны тов гармагц нэрсийн жагсаалтаас шүүх хуралдаан бүрд 10 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахимаар эрэмбэлэн сонгож тамгын газрын тушаалаар баталсан.



2.1.5.6 Мөн хуулийн 63.4-т заасны дагуу шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнд шүүх хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө мэдэгдэх хуудсаар болон утсаар мэдэгдэж, баримтыг хэрэгт хавсаргаж байна.

Ажил эрхэлдэг 3 иргэдийн төлөөлөгчийн томилох эрх бүхий албан тушаалтанд тамгын газрын албан бичгээр мэдэгдэл хүргүүлж шүүх хуралд оролцуулсан.

2.1.5.7 2024 онд 28 шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгч оролцсон бол 2025 онд 26 иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцож өмнөх оноос 2 буюу 0.9 хуваарь буурсан үзүүлэлттэй байна.

| 2024 он | 2025 он | Өсөлт/бууралт |
|---------|---------|---------------|
| 28      | 26      | 2 буурсан     |



**2.1.6 Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааны талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ.**

2.1.6.1 Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа бөгөөд ямар нэг алдаа зөрчил гараагүй байна.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 249 өргөдөл хэрэг, маргаан хүлээн авсан.

**Эрх зүйн маргааны төрөл**



2.1.6.2 Хүлээн авсан хэрэг, маргааныг эрх зүйн төрлөөр нь өмнөх оны үетэй харьцуулан төрлөөр харьцуулан үзвэл 2024 оны хүлээн авсан өргөдөл 2025 оны өргөдлөөс 0.04 хувиар буурсан, Шийдвэрлэсэн өргөдөл 3.4 хувиар буурсан, Амжилттай шийдвэрлэсэн өргөдөл өмнөх оноос 28.6 хувиар өссөн, Амжилгүй шийдвэрлэсэн өргөдөл өмнөх оноос 28.4 хувиар буурсан, татгалзсан өргөдөл өмнөх оноос 41.6 хувиар буурсан, Үлдэгдэл өргөдөл өмнөх оноос 38.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

| Төрөл                | 2024 он | 2025 он |
|----------------------|---------|---------|
| Хүлээн авсан өргөдөл | 250     | 249     |
| Шийдвэрлэсэн өргөдөл | 144     | 139     |
| Амжилттай болсон     | 63      | 81      |
| Амжилтгүй болсон     | 81      | 58      |
| Татгалзсан           | 77      | 45      |
| Үлдэгдэл             | 29      | 76      |

2.1.6.3 2025 онд нийт 81 эвлэрлийн өргөдөл амжилттай болсон. Үүнээс 68 эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахаар Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд шилжүүлж эвлэрлийн гэрээ байгуулсан. Мөн амжилттай дуусгавар болсон өргөдөл нийт 13 байна.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чанарыг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд 14.5 хувиар өсөж 58.2 хувь болсон байна.



2.1.6.4 Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд **1328** нэхэмжлэл хүлээн авч, шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа **249** өргөдөл, маргаан хүлээн авсан байгаа нь шүүхийн ачааллыг **18.75** хувиар бууруулсан үзүүлэлттэй байна.

2025 онд эвлэрүүлэн зуучлалын цахим уулзалт **13** өргөдөл дээр нийт **27** удаа зохион байгуулж гэр бүлийн болон хэргийн оролцогчдын оролцоог идэвхжүүлж, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

2.1.6.5 Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 33.1, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмын 29.1-д тус тус заасны дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах зорилгоор дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Увс аймгийн Өлгий, Өмнөговь, Ховд, Бөхмөрөн, Завхан, Наранбулаг, Тэс Зүүнговь зэрэг 8 суманд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх маргаан, ач холбогдол” сэдвээр иргэдэд сургалт зохион байгуулан мэдээлэл өгч ажиллалаа.



Зураг: Эвлэрүүлэн зуучлалын сургалтыг сумдад зохион байгуулав

2.1.6.6 Монголын хуульчдын холбооноос жил бүр 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулдаг "Про-поно" өдөрлөг, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Увс аймгийн Улаангом сумын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Нээлттэй өдөрлөг”-т оролцож, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг явуулж, өдөрлөгт ирсэн иргэдэд гарын авлага, брошур, нугалбар зэргээр үйлчилж, мэдээлэл өгч ажиллалаа.





Зураг: Нээлттэй хаалганы өдөрлөгт

2.1.6.7 Увс аймаг дахь шүүхийн Тамгын газраас эрхлэн гаргадаг “Нээлттэй шүүх” подкастад оролцож, Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, түүний ач холбогдол сэдвийн хүрээнд ярилцлага мэдээлэл өгч ажилласан. Уг подкастыг нийт 2,200 гаруй үзэгчид сонсож эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тодорхой мэдээллийг авсан байна.



2.1.6.8 Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны материалыг архивд шилжүүлсэн байдал:


2025 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар нийт 110 эвлэрүүлэн зуучлах ажиллагааны материалыг журамд заасны дагуу бүртгэлээр тухай бүрд нь архивд шилжүүлсэн. Үүнд: Эвлэрсэн материал 65, амжилтгүй болсон материал 45 тус тус шилжүүлж, Архив бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн байна.




| №  | Шүүхийн нэр, эвлэрүүлэн өгсөн дугаар   | Эрхлэн гаргачийн нэр | Урьдчил эвлэрүүлэн нэр | Эвлэрсэн эхэн | Эвлэрүүлэн зуучлагчийн нэр | Эвлэрүүлэн гаргачийн өгсөн | Материалын хуудсаны тоо, буудал ба үзүүлэлт | Увс аймаг дахь шүүхийн Архив тэмдэглэл                   | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн |
|----|--|----------------------|------------------------|---------------|----------------------------|----------------------------|---|--|--|
| 1  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |
| 2  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |
| 3  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |
| 4  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |
| 5  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |
| 6  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |
| 7  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |
| 8  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |
| 9  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |
| 10 | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2025 оны 09 дугаар сарын 20 өдөр 110 дугаар тоотой 1 дүгээр хэргэг, маргаан | М.Давлааганы         | М.Давлааганы           | М.Давлааганы  | М.Давлааганы               | М.Давлааганы               | 1 хуудас                                    | Архивт хүлээн авсан үзэгчид нэр, гарын үсэг, өгсөн өгсөн | М.Давлааганы   |

Зураг: Материалыг архивт хүлээлгэн өгсөн бүртгэлийн дэвтэр

Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 02 дугаартай тогтоолыг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс дагаж мөрдсөнтэй холбоотойгоор эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хэрэглэгдэх шүүх дэх баримт, тэмдэглэл, албан хэрэг хөтлөлтийн загварын дагуу нийт 15 баримт, тэмдэглэл, албан хэрэг хөтлөлтийн 7 бүртгэлийг шинэчлэн үнэн зөв хөтөлж байна.



| Д/д | Өргөдөл тасгалын нэр   | Эргэцүүлэгчдийн нэр | Ажил         | Эргэцүүлэн зуучлагчийн нэр | Шийдвэрийн байдал | Шүүхийн захирамжийн дугаар                 | Урьдчилсан үнэн зөв хөтөлж байгаа эсэх |
|-----|--|---------------------|--------------|----------------------------|-------------------|--|--|
| 46  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 47  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 48  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 49  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 50  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 51  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 52  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 53  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 54  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 55  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |
| 56  | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч | М.Сүхбаатар         | Хүлээн авсан | М.Сүхбаатар                | Хүлээн авсан      | Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх | Хүлээн авсан                           |



| №  | Өргөдөл тасгалын нэр | Эргэцүүлэгчдийн нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр | Өргөдөл тасгалын нэр |
|----|----------------------|---------------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| 1  |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |
| 2  |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |
| 3  |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |
| 4  |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |
| 5  |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |
| 6  |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |
| 7  |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |
| 8  |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |
| 9  |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |
| 10 |                      |                     |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |                      |

Зураг: Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд дахь бүртгэлийн дэвтрүүд

2.1.6.9 Эд мөрийн баримт: Шүүхийн тамгын газрын даргын 2025 оны А/03, А/61 дугаартай тушаалаар "Шүүхэд шилжүүлсэн эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хавсарган ирүүлсэн эд мөрийн баримтыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий комисс"-ыг тус тус шинэчлэн байгуулан ажиллаж байна.



Зураг: Комисс томилсон тушаал

Комисс дээрх хугацаанд нийт 2 удаа хуралдаж, ЭМБ-ыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл сонсож, хуулийн хүчин төгөлдөр болсон шийтгэх тогтоолд заасан эд мөрийн баримтуудыг буцаан олгох, устгах ажиллагааг хийсэн. 2025 оны байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд мөрийн баримт бүхий 66 хэргийг хүлээн авснаас 3 хэргийг прокурорт эд мөрийн баримтын хамт буцаасан, 60 хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хүргүүлсэн. Шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон нийт 204 хэргээс 2025 оны эхний хагас жилд 4 хэргийн, сүүлийн хагас жилд 10 хэргийн эд мөрийн баримтыг шийтгэх тогтоолд заасны дагуу устгаж, 15 хэргийн эд мөрийн баримтыг буцаан олгосон. 2025 оны байдлаар эд мөрийн баримт устгах ажиллагааг 2 удаа хийж 21 нэр төрлийн 37 ширхэг эд мөрийн баримтыг устгаж шийдвэрлэсэн байна.

| Эрүүгийн хэргийн үндэслэл | Хэрэгний үндэслэл | Хэрэгний үндэслэл | Хэрэгний үндэслэл |
|---------------------------|-------------------|-------------------|-------------------|
| 1                         | 2025.07.02        | Д.Оршимаа         | Д.Оршимаа         |
| 2                         | 2025.02.18        | И.Ганзориг        | И.Ганзориг        |
| 3                         | 2025.02.14        | И.Оршимаа         | И.Оршимаа         |

Зураг: Эд мөрийн баримт устгасан жагсаалт



Зураг. Эд мөрийн баримт устгаж буй байдал

### 2.1.7 Шүүхийн тамгын газар шүүхийн мэдээллийн технологийн чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ.

**2.1.7.1** "Шүүхийн мэдээллийн технологийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 5 дугаар зүйлийн хэрэгжилтийн хүрээнд шүүгч, ажилтнуудын Компьютерийг гаднын нөлөөллөөс хамгаалах нь журмын дагуу Microsoft компаниас албан ёсоор Windows 10 үйлдлийн системтэй компьютерт 2025 оны 10 дугаар сарын 14-ны өдрөөс эхэлж техникийн туслалцаа, функцийн шинэчлэлт болон аюулгүй байдлын шинэчлэлтүүдийг цаашид өгөхгүй гэдгийг албан ёсны цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдэгдсэн. Иймд шүүгч ажилчдын компьютерт үзлэг хийж windows 10 үйлдлийн системтэй компьютерийн тоог гаргаж хэрэгтэй дата мэдээллүүдийг нь D disc дээр нь хуулж үйлдлийн системийн шинэчлэл хийж windows 11 pro 64bit үйлдлийн системүүдийг суулгаж ажилласан.

"Шүүхийн мэдээллийн технологийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 5 дугаар зүйлийн 5.5.1-т заасны дагуу Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс ирүүлсэн 35 ширхэг Trend micro Apex One Security Agent антивирусын программыг шүүгч, ажилтнуудын компьютерт суулгаж, компьютер бүрд temp файлуудыг устгах, үйлдлийн системийн аюулгүй байдлын шинэчлэлтүүдийг тогтмол хийх зэрэг программ хангамжийн үйлчилгээнүүдийг тогтмол хийж энэ талаар бүртгэлийн дэвтэр дээр бүртгэж байна. 2024 онд нийт 8 компьютерт үйлдлийн системийг сольсон байна.



Зураг: 2025 онд ШЕЗ-өөс тараасан вирусийн программ

2025 онд дараах тоног төхөөрөмжүүдийг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

1. Дэлгэц 27 inch HP 1 ширхэг
2. Олон үйлдэлт хэвлэгч 2 ширхгийг худалдан авч шүүгч болон шүүхийн захиргааны ажилчдад тавьж өгсөн.
3. HP брэндийн Суурин компьютер i5 13500 10 ширхэг ирснийг шүүгч, захиргааны ажилтан нарт тараан өгч ажилласан.
4. “Цахим шүүх 2.0” системд шүүхэд ирсэн хэргүүдийг цахим хэлбэрт шилжүүлэх цахимжуулалтын ажилтад зориулан сканер DS-570W11 1 ширхэг ирснийг хүлээлгэн өгсөн.
5. Шүүхийн архивыг цахимд шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Сканер DS70000 1 ширхэг ирснийг хүлээн авч ашиглалтад оруулж ажилласан.
6. “Цахим шүүх 2.0” систем 2025 оны сүүлээр нэвтэрч байгаатай холбоотойгоор интернетийн хурдныг дэмжих зорилгоор Увс аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүх, шүүхийн тамгын газрын сүлжээ салаалагч төхөөрөмжид парк шинэчлэл хийж Tr-Link брэндийн 16 порт switch /1000 gb/ 1ш, 24 порт switch /1000gb/ 2ш, 8 порт switch /1000gb/ 8 ширхэг нийт 11 ширхэг сүлжээ салаалагчийг сольж ажилласан.




**2.1.7.2** 2025 онд шинээр томилолдон шүүгчийн туслах 5, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга 4 нарт хэргийн хөдөлгөөний программ хангамжийн талаарх сургалтыг 2025 оны 01 сарын 20-ны өдөр танхимаар, мөн ганцаарчилсан хэлбэрээр нийтдээ 9 удаагийн сургалтыг явуулсан мөн шүүхийн архивын баримтыг цахимд оруулах талаар гэрээт ажилтанд сканер, компьютерийн программ хангамжийн талаар сургалтыг 1 удаа, шүүх, шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд

цахим шуудан хэрэглэх журам батлагдсанаар шүүгчийн туслах, эвлэрүүлэн зуучлагч нийт 14 ажилтанд цахим шуудангийн хэрэглээ, мэдээллийн аюулгүй байдлын талаар танхимын сургалтыг 4 удаа хийсэн байна.

**2.1.7.3** Хэргийн хөдөлгөөний болон бусад дотоод программ хангамжийн хэвийн ажиллагааг ханган ажиллах, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, эвлэрүүлэн зуучлагч нараас системээс авагдсан дугаар, хэргийн оролцогчийг буруу бүртгэх, эрх зүйн актын огноо болон дугаарыг засварлах зэрэг **24** хүсэлт ирүүлснийг шүүхийн тамгын газрын даргад танилцуулж мэргэжилтний эрхээр засварлах боломжгүй хүсэлтийг шүүхийн тамгын газрын албан бичгээр цахим хүсэлтийн системд бүртгэж Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээлэл технологийн газарт илгээж тухай бүр нь шийдвэрлүүлж нэгдсэн системийн хэвийн ажиллагаанд оруулсан нь шүүхийн захиргааны ажилтнуудын систем дээр гаргасан алдаа өмнөх 2024 оноос 50 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

| Хэрэглэгчээс шалтгаалсан алдаа | Системээс шалтгаалсан алдаа | Өсөлт/бууралт   |
|--------------------------------|-----------------------------|-----------------|
| 24                             | 55                          | 50 хувиар өссөн |



Зураг: Шүүгчийн туслах, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн нараас бүртгэл хяналтын нэгдсэн системд алдаа залруулахаар ирүүлсэн хүсэлтийг шүүхийн тамгын газрын цохилтыг үндэслэж засвар оруулж ажиллаж байна.

Гаргасан алдааны нөхцөл байдлыг авч үзвэл: Хэрэглэгчээс шалтгаалж гарсан алдааны хувьд эрх зүйн актыг буруу оруулах, эрх зүйн актын төрлийг буруу сонгож авсан тохиолдлууд багтаж байгаа бол системээс шалтгаалсан алдаанд хэргийн хөдөлгөөний бүртгэл хяналтын нэгдсэн системийн гацалт, систем орохгүй байх зэргээс шалтгаалж эрх зүйн актын дугаар авч чадахгүй маргааш нь нөхөж авах, иргэнээс ирүүлсэн нэхэмжлэл, хуулийн хугацаа дуусах өдөр нь болсон гомдол хүсэлтийг тухай өдөрт нь багтааж авч чадаагүй зэрэг алдаа зонхилж байна.


Хуулийн хугацаа дуусах өдөрт нь багтааж системд бүртгэж чадаагүй гомдол хүсэлтийг шүүхийн тамгын газрын дарга болон ШЕЗ-ийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэст мэдэгдэж байна. Систем хэвийн болсон үед бүртгэх, энэ талаар тэмдэглэл хөтлөх, огноог засварлах зэргээр хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

2.1.7.4 Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 109 дугаартай тогтоолоор баталсан "Шүүх хуралдааны дууны, дуу-дүрсний бичлэг хийх, архивлах ажлыг зохион байгуулах журам"-ийн хүрээнд шүүх хуралдааны явцыг дууны, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулж, архивлах ажиллагааг гүйцэтгэх ажлын хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 20-оос 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд эрүү, иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн **5128** шүүх хуралдааны дуу-дүрсний бичлэгийг хийж серверт бичиж хадгалжээ.

Шүүх хуралдааны явцыг дуу, дүрс бичлэгээр бичиж хадгалсан байдлыг харьцуулбал

| 2024 он | 2025 он | Өсөлт/бууралт    |
|---------|---------|------------------|
| 4851    | 5128    | 5.7 хувиар өссөн |

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны явцыг дуу-дүрсээр баталгаажуулахтай холбоотой бүртгэлийг хөтөлж шүүхийн мэдээллийн технологийн мэргэжилтэнтэй хүлээлцэж байна.



| №  | ШХНБД-ийн нэр | Огноо      | Хэдэн дуу-дүрсний бичлэг хийсэн | Нийт бичлэг (тоо) | Бүх бичлэг хэргийн эхэл | Хэргийн бичлэг бол шалтгаан              | Нийт цагдаагийн | Хүлээлцсэн мэдээллийн технологийн мэргэжилтэн |
|----|---------------|------------|---------------------------------|-------------------|-------------------------|--|-----------------|---|
| 8  | Х. Аюултөмөр  | 2025.01.02 | 4                               | 6                 | Хэргийн                 |  | Х. Аюултөмөр    | Х. Аюултөмөр                                  |
| 9  | Х. Аюултөмөр  | 2025.01.03 | 4                               | 9                 | Хэргийн                 |  | Х. Аюултөмөр    | Х. Аюултөмөр                                  |
| 10 | Х. Аюултөмөр  | 2025.01.04 | 1                               | 2                 | Хэргийн                 |  | Х. Аюултөмөр    | Х. Аюултөмөр                                  |
| 11 | Х. Аюултөмөр  | 2025.01.05 | 9                               | 18                | Хэргийн                 |  | Х. Аюултөмөр    | Х. Аюултөмөр                                  |
| 12 | Х. Аюултөмөр  | 2025.01.06 | 4                               | 6                 | Хэргийн                 |  | Х. Аюултөмөр    | Х. Аюултөмөр                                  |
| 13 | Х. Аюултөмөр  | 2025.01.07 | 10                              | 20                | Хэргийн                 |  | Х. Аюултөмөр    | Х. Аюултөмөр                                  |
| 14 | Х. Аюултөмөр  | 2025.01.08 | 3                               | 6                 | Хэргийн                 | Х. Аюултөмөр, Х. Аюултөмөр, Х. Аюултөмөр | Х. Аюултөмөр    | Х. Аюултөмөр                                  |

Нийт  
[www.court.uv.gov.mn](http://www.court.uv.gov.mn) [www.facebook.com/uvs.courts](https://www.facebook.com/uvs.courts)

Зураг: Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга болон мэдээлэл технологийн мэргэжилтэн нарын шүүх хуралдааны бичлэг хүлээлцэх дэвтэр

2025 онд Шүүх хуралдааны явцын бичлэгтэй танилцах хүсэлт 1, хуулбарлаж авах хүсэлт 3 ирснийг шүүхийн Тамгын газрын даргын зөвшөөрлийн дагуу флаш, DVD, зөөврийн хард диск нь дээр хуулбарлан өгч ажилласан.


Мэдээлэл технологийн мэргэжилтэн нь шүүх хуралдааны заалны бичлэгийн төхөөрөмжид хяналт тавьж засвар үйлчилгээг тогтмол хийж хэвшсэн.





2.1.7.7 Увс аймаг дахь шүүхийн тамгын газар, Увс аймгийн Шуудангийн үйлчилгээний газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Увс аймгийн анхан болон давж заалдах шатны шүүхэд Монгол шуудан ХК-ийн Гибрид шуудангийн үйлчилгээ нэвтрүүлээ.


“Гибрид” шуудангийн үйлчилгээ нь шүүхээс албан байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүст хаягласан шүүх хуралдаанд дуудан ирүүлэх болон шүүхэд дуудан ирүүлэх мэдэгдэх хуудсыг хүлээн авч түргэн шуурхай хүргэх шуудан хүргэлтийн үйлчилгээ бөгөөд шүүхийн үйлчилгээг хөнгөвчлөх, түргэн шуурхай хүргэхэд ач холбогдолтой юм.



Зураг: Монгол шуудах ХХК-ий “Гибрид шуудангийн” харагдах байдал


2.1.7.8 ТУСГАЙЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ 75<sup>4</sup>.4.Энэ хуулийн 75<sup>4</sup>.2, 75<sup>4</sup>.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

Хуулийн хүрээнд монгол улсын иргэн бүрд үүсэн үндэсний цахим хаяг руу мэйл явуулах шаардлага гарсан тул үндэсний дата төвөөс /court.uv.gov.mn/ домэйн



хаяг дээрээ мэйл үүсгэн авч ажиллагаанд оруулан тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа саадгүй тасалдахгүй явагдаж байна.

**2.1.7.9** Увс аймгийн Шүүхийн байранд төрийн цахим үйлчилгээний “гэрэгэ” киоск машин ажиллаж байна. Уг киоск машинаар иргэн, хуулийн этгээдээс шүүхэд улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн архивын үйлчилгээний төлбөрийг шууд төлөх боломжтой юм. Энэхүү үйлчилгээ нэвтэрснээр Увс аймгийн иргэд шүүхээр үйлчлүүлэхэд цаг хугацаа алдахгүй, нэг цэгээс үйлчилгээ авах боломж бүрдэхийн зэрэгцээ төр, хувийн хэвшлийн 60 байгууллагын 600 гаруй үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай авах боломжтой боллоо.




Зураг: Төрийн үйлчилгээний “Хурдан” болон “Гэрэгэ” киоск машины бодит зураг болон зааврын хамт

**2.1.7.10** Шүүхийн нэгдсэн сүлжээг зөвхөн шүүхийн байрнаас холбогддог байх бололцоог техникийн түвшинд бүрдүүлэн ажиллаж байна.

Шүүхийн байрын дотоод сүлжээний архитектур болон дотоод, гадаад сүлжээний палан /topology/ зургийг гаргаж ажилласан.

Увс аймгийн анхан болон давж заалдах шатны шүүх болон шүүхийн тамгын газрын дотоод сүжээ салаалагч төхөөрөмжийг 1000mbps хурдтай свичээр сольж дотоод сүлжээнд мэдээлэл дамжуулах хурд өссөн байна.



Зураг: Увс аймаг шүүхийн тамгын газрын 1, 2, 3 давхрын дотоод болон гадаад сүлжээний палан /topology/ зургийг гаргаж ажилласан.

**2.1.7.11** Шүүхийн тухай хуулийн 12.7.2, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 276 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг цахим хуудаст байршуулах журам”-ын 2.3 дахь хэсэгт тус тус зааснаар Увс аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхээс нийт **56** удаагийн шүүх хуралдааныг шууд дамжуулсан байна.



Зураг: Шууд дамжуулсан шүүх хуралдаан

2.1.7.12 Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй ил тод байх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 276 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг цахим хуудаст байршуулах журам”-ын 2.2 дахь хэсэгт тус тус зааснаар Увс аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхээс нийт **13** удаагийн шүүх хуралдааныг бичлэгийг шүүхийн Тамгын газрын цахим хуудаст байршуулсан байна.

| № | Шүүгдэгч, Нэхэмжлэгч, түүний амьсгалыгч, ИТгэлмэлэгч | Холбогч, Хариуцагч, түүний амьсгалыгч, ИТгэлмэлэгч | Жонбогдсон хэрг, Агуулга  | Шүүх бүрэлдэхүүн                   | Төрөл           | Шүүх хуралдаан өмгөөлсөн огноо | Үзэж | Бичлэг устгах огноо |
|---|--|--|---|------------------------------------|-----------------|--------------------------------|------|---------------------|
| 1 | Ч.Данжин (Т.Увс)                                     |  | ЗХТ-ийн 27, 10-6 /Тээврийн хэрэгсэл жолоогдох эрхээ хасуулсан хэрэг/ Согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан асаахыг зэмлэж журмын дагуу шалгуулахыг зайлшгүйсэй | Л.Дэлгэр, Ж.Отгонболд, Н.Манжаргал | Зөвчигийн хэрэг | 2025.01.30 /15.20/             | УЗХХ | 2025.03.27          |
| 2 | М.Пажмасуран   |  | ЗТХ-ийн 14, 2, 6, 5, 1, 14, 7, 10, 10, 2, 7 Төлөөний зэмлэлийг үргэлжлүүлж, Согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон  | Н.Манжаргал, Ж.Отгонболд, П.Алтан  | Зөвчигийн хэрэг | 2025.01.30 /13.40/             | УЗХХ | 2025.03.27          |
| 3 | Ч.Дугласуран (СФ. Д.Бунжага)                         | П.Баттулга (СФ. Г.Экэмшэл)                         | ЗТХ-ийн 5, 2-1, 1, 3, 1-4 /Өмч нийтийн гэрээт бүсдийн амгалан тайван байдал алдагдуулж, өмч нийтийг үл хяндтгай/  | Н.Манжаргал, Ж.Отгонболд, П.Алтан  | Зөвчигийн хэрэг | 2025.02.14 /14.00/             | УЗХХ | 2025.03.27          |

Зураг: Шүүхийн Тамгын газрын цахим хуудаст болох [www.court.uv.gov.mn](http://www.court.uv.gov.mn) дэмэйн хуудсанд байршуулсан шүүх хуралдааны бичлэг


## 2.1.8 Архив албан хэрэг хөтлөлт шүүхийн тусгай архивын чиглэлээр

2.1.8.1. Архив албан хэрэг хөтлөлтийн хүрээнд: Увс аймгийн шүүхийн Тамгын газарт Шүүхийн ерөнхий зөвлөл болон бусад шүүхүүд, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгүүдийг албан хэрэг хөтлөх стандартын дагуу хүлээн авч, бүртгэл хяналтын карт хөтөлж, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, хяналт тавьж хариуг хуулийн хугацаанд нь өгөх ажлыг бүрэн хэвшүүлсэн.

2025 онд тус шүүхийн Тамгын газарт иргэн, хуулийн этгээд, албан байгууллагаас нийт **444** албан бичиг ирснээс **127** бичиг нь хариугүй, **317** бичиг нь хариутай буюу **317** албан бичгийн хариуг тухай бүр хугацаанд нь хүргүүлсэн байна.

Тамгын газарт иргэн, хуулийн этгээд, албан байгууллагаас ирсэн бичиг нь 2025 онд өмнөх оноос **7.4** хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2.1.8.2 Шүүхийн нэршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан шүүхийн хэвлэмэл хуудасны эхийг батлуулж, эрх бүхий байгууллагаар хэвлүүлэх ажлын хүрээнд:



Анхан болон давж заалдах шатны шүүх, шүүхийн Тамгын газарт ашиглагдах 37 нэр төрлийн хэвлэмэл хуудсыг Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоол, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаал, "Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага" MNS 5140-3:2021-д нийцүүлэн бэлтгэж, Архивын ерөнхий газраар батлуулсан, тухайн хэвлэмэл хуудасны үндэсний бичгийн загварыг Увс аймгийн төрийн архивын Архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын байцаагчаар баталгаажуулан Увс аймгийн архивын тасгаар хэвлүүлэн бэлтгэж 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаандаа хэрэглэж байна.



Зураг. Хэвлэмэл хуудас баталгаажуулсан байдал

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Анхан болон давж заалдах шатны шүүх, шүүхийн Тамгын газар А4 хэвлэмэл хуудас 60960, А5 хэвлэмэл хуудас 6950 тус тус хэрэглэж, А4 хэвлэмэл хуудас 500 ширхэг, А5 хэвлэмэл хуудас 320 ширхэг, нийт 820 хэвлэмэл хуудасны үлдэгдэлтэй байна.



Зураг. Хэвлэмэл хуудасны индекс болон хөдөөлөх, олгох, зарцуулалтад хяналт тавих ажилтныг томилох тухай.

Увс аймаг дахь шүүхийн Тамгын газрын даргын 2025 оны А/87 дугаар тушаалаар хэвлэмэл хуудасны индекс болон хадгалах, олгох, зарцуулалтад хяналт тавих ажилтныг томилсон.


2.1.8.3 Шүүхийн Тамгын газар нь 2025 онд “Монгол шуудан” ХК-ийн Увс аймгийн шуудан үйлчилгээний газартай 2025 оны 01 дүгээр сард шуудангийн үйлчилгээ үзүүлэх гэрээгээ шинэчлэн байгуулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан “Хавтас хэрэг илгээх, хүлээн авах журам”-ын дагуу хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна.

“Монгол шуудан” ХК-ийн шуудангийн үйлчилгээг ашиглан богцоор 63 удаа хэрэг хүргүүлж, 58 удаа хэрэг хүлээн авсан.

2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар шуудангаар 6199 удаагийн бичиг хүргэж ажилласан байна.

2.1.8.4 Увс аймаг дахь шүүхийн тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02 тоот тушаалаар баримт нягтлан шалгах комиссыг байгуулсан байдаг.

Тус комисс нь 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдөр “Эрүүгийн хэргийн данс бүртгэлийг Улсын ерөнхий прокурорын газрын эрүүгийн тусгай архивын дэргэдэх баримт нягтлан шалгах арга зүйн хурлаар хэлэлцүүлэн батлуулах тухай” хуралдсан байна.



Байгууллагын зохион байгуулалтын нэгжид тухайн жилд хөтлөгдөх албан хэргийг тодорхой нэр төрөл, асуудлын сэдвээр төрөлжүүлэн хадгалах хугацаа, хариуцах албан тушаалтны нэрийг заасан лавлах тоо бүртгэлийн баримт юм.


Баримт бичиг нягтлан шалгах комисс нь 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдөр “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг өөрчлөн баталсан.

2.1.8.5 2025 онд шүүхийн архивд засвар хийж шинээр 8 нягтруулсан шүүгээ, 2 ширхэг төмөр тавиур, 1 жижиг төмөр сейфийг стандартын дагуу байршуулсан.



| №  | Хөтлөх хэргийн нэр | Хөтлөх хэргийн өдөр | Хөтлөх хэргийн төрөл | Тайлбар            |
|----|--------------------|---------------------|----------------------|--------------------|
| 1  | 10101              | 2024.01.15          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |
| 2  | 10102              | 2024.02.01          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |
| 3  | 10103              | 2024.03.10          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |
| 4  | 10104              | 2024.04.20          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |
| 5  | 10105              | 2024.05.05          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |
| 6  | 10106              | 2024.06.15          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |
| 7  | 10107              | 2024.07.01          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |
| 8  | 10108              | 2024.08.10          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |
| 9  | 10109              | 2024.09.20          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |
| 10 | 10110              | 2024.10.05          | Хөтлөх хэргийн нэр   | Хөтлөх хэргийн нэр |

Шуудан үйлчилгээг ашиглаж явуулсан албан бичиг, эрх зүйн актыг хүргүүлсэн байдлыг авч үзвэл:



Хадгаламжийн санд баримтыг харанхуй нөхцөлд хадгалах, цонхонд хөшиг татах, байгалийн гэрлийн нөлөөг багасгах, гэрэлтүүлгийн хэмжээ нь 50 люк-ээс дээшгүй байх, гэрлийг тавиур шүүгээнээс 50 см-ын зайнд байрлуулах, гэрэл нь хамгаалалтын бүрхүүлтэй байх норматив дэглэмийг мөрдөн ажиллаж байна.





Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм, Архивын аюулгүй ажиллагааны журамд заасны дагуу тус өрөөнд автомат галын хор 2 ширхэг, 60\*60 хэмжээтэй лед гэрэл 4 ширхэг суурилуулсан.

Архив нь данс, түүхчилсэн лавлах заавал үйлдэх бөгөөд архивын эрдэм шинжилгээний бусад лавлах (каталог, тойм гэх мэт)-ын хэрэгцээ шаардлагыг харгалзан тэдгээрийг "Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын дагуу үйлдэж болно. Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 3.10-д зааснаар архивын баримтыг байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлддэг.

Увс аймаг дахь шүүхийн Тамгын газрын архивд данс бүртгэлээр байнга хадгалах хадгаламжийн нэгж **2430**, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж **30**, түр хадгалах хадгаламжийн нэгж **20015** тус шүүхийн Тамгын газрын хөмрөг үүсгэгч архивд нийт **22475** хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

2.1.8.6 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар архивд хэрэг хүлээлгэн өгснийг хүснэгтээр харуулбал:






Эвлэрүүлэн зуучлалд 139 хэрэг шийдвэрлэснээс архивд 110 хэрэг хүлээлгэн өгч 87 хувьтай өгсөн байна.

2.1.8.7 Улсын Ерөнхий Прокурорын газрын эрүүгийн хэргийн тусгай архивд эрүүгийн хэргийн байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл 384-402 буюу 9 хэрэг, нууц 1 хэрэг тус тус хүлээлгэн өгсөн.

Увс аймгийн прокурорын газарт шүүхээр ердийн журмаар шийдвэрлэсэн Зөрчлийн хэргийн түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл 2790-3770 буюу **981** хэрэг, эрүүгийн хэргийн түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл 1296-1626 буюу **253** хэрэг тус тус хүлээлгэн өгсөн.



Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон Шүүхийн тусгай архивын ажиллах журам, Шүүхийн архивын ажиллах журамд заасны дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн албан бичиг, шүүгчийн захирамжид үндэслэн нийт 25 хэргийг дотоодод шилжүүлсэн бөгөөд хуульд заасан хугацаанд хэргийг буцаан ирүүлсэн байна.



Зураг: Архиваас түр олгосон баримтын бүртгэл

• ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр шүүхийн тамгын газрын дотоод хяналт, шинжилгээ-үнэлгээг, Live.mn хөтлөлтийн мэдээг 7 хоног, сар, улирал, хагас жилээр хийж хамт олны хурлаар хэлэлцүүлж, алдаа зөрчлийг цаг тухай бүрд нь илрүүлж, залруулах, цаашид алдаа гаргахгүй байх талаар зөвлөн тусалж ажилссанаар алдаа, зөрчил буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Хэргийн хөдөлгөөний чиглэлээр 7 хоног бүр хяналт шалгалт хийж мэдээлэл бэлтгэн хамт олны шуурхай ярианд танилцуулж хэвшсэн ба 2025 оны хэргийн хөдөлгөөний удирдлагын I, II, III дугаар улирлын цахим хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 93.7, 95.4, 94.2 оноо буюу “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чанар 2024 онд 43.7 хувьтай байсан бол 2025 онд 14.5 хувиар өсөж 58.2 хувь үзүүлэлттэй байна.

Увс аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхээс нийт 56 удаагийн шүүх хуралдааныг цахимаар шууд дамжуулсан байна. Шүүх хуралдааны бичлэгийг шууд дамжуулснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нээлттэйгээр, ил тод олон нийтэд хүрч байна.


Шүүхийн шийдвэрийг цахим хуудсанд байршуулсан талаар мэдээллийг сар бүр гаргаж, шүүхийн шийдвэрийг байршуулж буй байдалд тогтмол хяналт тавьж, илэрсэн алдаа зөрчлийн талаар шүүгчийн туслах нарт мэдээлэл хийж гарсан алдаа зөрчлийг цаг алдалгүй арилгуулж хэвшлээ.

2025 онд “Гибрид” шуудангийн үйлчилгээг орон нутагт анх удаагаа нэвтрүүлсэн. “Гибрид” шуудангийн үйлчилгээ нь шүүхээс албан байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид шүүхийн мэдэгдэх хуудсыг цахимаар хүргүүлэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг богино хугацаанд шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

Увс аймгийн Шүүхийн байранд төрийн цахим үйлчилгээний “Хурдан” киоск машин байршуулсан. Уг киоск машинаар иргэн, хуулийн этгээдээс шүүхэд улсын



Анхан болон давж заалдах шатны шүүхэд 3 эрэгтэй, 6 эмэгтэй шүүгч, тамгын газарт 11 эрэгтэй, 17 эмэгтэй ажилтан, нийт 37 шүүгч ажилтнууд ажиллаж байна.



2.2.1.2 Шүүхийн тамгын газрын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд байгууллагын удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой “А” тушаал 67, шүүхийн хүний нөөцийн удирдлагын чиглэлээр “Б” тушаал 36, нийт 103 тушаал гаргасан болно.



2.2.1.3 Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.3-д заасны дагуу Зохион байгуулалтын хэлтсийн дарга 1 /нэг/, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга 3 /гурав/, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн 1 /нэг/ сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг холбогдох материалын хамт ШЕЗ-ийн хүний нөөцийн газарт 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 92, 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 134 дүгээр албан



бичгээр хүргүүлж тус тус хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 22 дугаар тогтоолоор шүүх хуралдааны нарийн бичгийн даргын 3 сул орон тоог нөхсөн. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 371 тоот албан бичгээр шүүх хуралдааны нарийн бичгийн дарга 1 /нэг/ сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг холбогдох материалын хамт ШЕЗ-ийн хүний нөөцийн газарт хүргүүлсэн байгаа болно.

2.2.1.4 Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3-т заасны дагуу хүүхэд асрах чөлөөтэй байгаа ба түр орлон гүйцэтгэгчээр 1 албан хаагч, сул орон тоон дээр 2 албан ажиллаж байна.

2.2.1.5 2025 онд өөр байгууллагад шилжсэн болон Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйл, Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмын дагуу сэлгэн томилогдсон албан хаагч байхгүй болно.

2.2.1.6 Төрийн жинхэнэ албан тушаалд шинээр томилогдсон 3, төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдсон 1 албан хаагчийн хувийн хэргийг цаасаар болон цахимаар шинээр нээж, мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Төрийн албаны хүний нөөцийн системд бүрэн оруулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаартай тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын 2.1.1-т зааснаар хүний нөөцийн ажилтан шүүхийн захиргааны 15, үйлчилгээний 10 ажилтны хувийн хэргийн хавтасны эхний нүүрэнд товьёг хийж, хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжуулалтад хяналт тавин ажиллаж байна.

2.2.1.7 Монгол Улсын Их хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 21 дугаартай тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалтны зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу шинээр зэрэг дэв авах албан хаагч байхгүй, харин зэрэг дэв ахиулан олгуулахаар шүүхийн захиргааны 1 ажилтны материалыг 2025 оны хагас жилээр Шүүхийн Ерөнхий Зөвлөлд хүргүүлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025.01.24 №19 дугаар тушаалаар шүүгчийн туслах Д.Нямжав, мэдээлэл технологийн мэргэжилтэн Д.Цэвээндорж Дэс түшмэлийн "Дөтгөөр" зэрэг, шүүгчийн туслах Т.Жаргалсайхан

Дэс түшмэлийн "Дэд" зэрэг, шүүгчийн туслах Б.Энхтуяа Дэс түшмэлийн "Гутгаар" зэрэг, 2025.09.04 №133 дугаар тушаалаар шүүгчийн туслах Г.Баярхүү Дэс түшмэлийн "Дэд" зэрэг олгогдсон байдаг.

| № | Нэр              | Төрийн албан хаагчийн үйлчилгээний газар | Төрийн албан хаагчийн үйлчилгээний газрын дарга | Төрийн албан хаагчийн үйлчилгээний газрын дарга | Төрийн албан хаагчийн үйлчилгээний газрын дарга |
|---|------------------|--|---|---|---|
| 1 | Д.Нямжав         | Шүүхийн ерөнхий зөвлөл                   | Д.Нямжав  | Д.Нямжав  | Д.Нямжав  |
| 2 | Д.Цэвээндорж Дэс | Шүүхийн ерөнхий зөвлөл                   | Д.Нямжав  | Д.Нямжав  | Д.Нямжав  |
| 3 | Т.Жаргалсайхан   | Шүүхийн ерөнхий зөвлөл                   | Д.Нямжав  | Д.Нямжав  | Д.Нямжав  |
| 4 | Б.Энхтуяа        | Шүүхийн ерөнхий зөвлөл                   | Д.Нямжав  | Д.Нямжав  | Д.Нямжав  |
| 5 | Г.Баярхүү        | Шүүхийн ерөнхий зөвлөл                   | Д.Нямжав  | Д.Нямжав  | Д.Нямжав  |

Зураг: Зэрэг дэв олгох тогтоол, Зэрэг дэв олгох тогтоолын хавсралт

2.2.1.8 Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслол журам"-ын дагуу шүүгчийн туслахын албан тушаалд томилогдсон Д.Нямгэрэл, Б.Байгальмаа Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөв.



2.2.2 Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэх, чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ.

2.2.2.1 Шүүхийн тамгын газрын "Сургалт, судалгааны хороо" нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг шүүгч ажилтнуудаас санал авч 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр тамгын газрын даргаар батлуулж 3 чиглэлийг 13 ажил зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс:

Мэдээлэл технологийн мэргэжилтэн Д.Цэвээндорж 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 95 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүх, шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд цахим шуудан хэрэглэх журам"-ын зохицуулалт, анхаарах асуудал,

2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Гибрид шуудангийн ашиглалт болон зааварчилгааны талаарх,

2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудаст байршуулах журам"-ын хэрэгжилт,

2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Увс аймаг дахь шүүхийн Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан А.Мөнхзул шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад ХАСХОМ гаргахад анхаарах асуудлын талаар,

2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ахмад, зөвлөх багш М.Мягмаржавыг урьж "Ёс зүй ба ёс суртахуун",

Увс аймаг дахь тамгын газрын Зохион байгуулалтын хэлтсийн дарга Б.Доржсүрэн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр шинээр ажилд томилогдсон шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс баталсан шүүн таслах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэглэж байгаа журмуудыг танилцуулах сургалт,





2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэгийг урьж оролцуулан Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн албан хаагч гэж хэн бэ” сэдэвт сургалт,



Увс аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах Ш.Анхцэцэг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 39 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам” болон журмын нэмэлт өөрчлөлтийн талаар сургалт,

2025 оны 04 дүгээр сарын 18-ны Увс аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Н.Мөнхжаргал, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Н.Мөнх-Эрдэнэ нар “Иргэний эрх зүйн бодлого бодох аргачлал” сэдвээр сургалт,



2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Гансүх “Эрүүгийн эрх зүйн бодлого бодох аргачлал” сургалт,



2025 оны 05 дүгээр сарын 01-ний өдөр Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.Батдорж “Захиргааны эрх зүйн бодлого бодох аргачлал” сургалт,

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Ц.Нууцзаяа 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдөр “Ажлын байрны сэтгэл зүй” сэдвээр сургалт,

2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шүүгч Б.Мөнхзаяа “Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги” сэдэвт сургалт,

Ёс зүйн дэд хорооноос албан хаагчдаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд шүүхийн тамгын газрын албан хаагчдад

ᠤᠪᠰ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠰᠢᠬᠡᠭᠢᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠠᠰᠢᠷᠢᠨ ᠦᠶᠡᠯ ᠠᠵᠢᠯᠢᠭᠠᠭᠠᠨᠢ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ-2025


“Шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам”-аар сургалт,



2025 оны 11 дүгээр сарын эхнээс 11 сарыг дуустал 7 хоног бүрийн 4 дэх өдөр Монгол бичгийн сургалт зэргийг тус тус зохион байгуулж байна.

2.2.3 Шүүхийн захиргааны ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах,

2.2.3.1 Шүүхийн тамгын газрын ажилтнуудад чөлөөний хуудсаар 34, тушаалаар 11 удаа чөлөө нийт 45 удаа олгосон байна.



2.2.3.2 2025 онд төрийн болон салбарын шагналд шүүгч, ажилтнуудыг тодорхойлж хамт олны хурлаар хэлэлцэн материалыг Шүүхийн тамгын газрын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 39 дугаартай албан бичгээр Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэн ажиллалаа.



Шагнагдсан алба хаагчид

Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одонгоор Увс аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгч Н.Мөнхжаргал, Хөдөлмөрийн хүндэт медалиар Нягтлан бодогч А.Мөнхзул, Хууль зүйн яамны Тэргүүний ажилтнаар Эвлэрүүлэн зуучлагч Ж.Отгонням, Жуух бичгээр ТГД, Л.Баттулга, Шүүгчийн туслах Б.Сарантуяа, Т.Жаргалсайхан, Б.Энхтуяа, АБХЭ Д.Ариунтуяа, ШЕЗ-ийн Хүндэт тэмдгээр

шүүгчийн туслах Ш.Анхцэцэг, Өргөмжлөлөөр шүүх хуралдааны нарийн бичгийн дарга П.Цогзолмаа, Жолооч Х.Хашхүү нарыг тодорхойлж тус тус шагнагдсан.

### 2.2.3.3 Шүүгч ажилтнуудын дунд волейболын лигийн аварга шалгаруулах



тэмцээнийг 2025 оны 02 дугаар сараас эхлэн зохион байгуулж явууллаа. Мөн 7 хоног бүрийн 2 дахь өдөр 18:00 цагаас Увс аймгийн биеийн тамир спортын газрын спорт заалд тоглож байна.

2.2.3.4 Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 104 жил, Чөлөөлөх дайны 80 жилийн ойг тохиолдуулан Увс аймаг дахь Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд спортын олон төрөлт “ЦОГЦОЛБОР” тэмцээнд 15 байгууллагын 400 гаруй тамирчид 170 гаруй багц медаль, шилжин явах цомын төлөө өрсөлдсөнөөс снукер бильярдны төрөлд Шүүхийн тамгын газрын дарга Л.Баттулга “Алтан медаль”, шатрын төрөлд шүүгчийн туслах П.Янжиндулам “Алтан медаль” тус тус хүртлээ.



2.2.3.5 Баян-Өлгий аймагт Шүүх байгуулагдсаны 85 жилийн ойг тохиолдуулан баруун бүсийн шүүхүүдийн дунд шилжин явах цомын төлөөх “АЛТАЙ ТАВАН БОГД-2025” спортын таван төрөлт тэмцээнийг 2025 оны 06 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд Баян-Өлгий аймгийн төвд зохион байгуулагдлаа.

Уг тэмцээнд Увс, Ховд, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхүүд, Ховд аймгийн Булган сум дахь, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхүүдийн шүүгч, ажилтнууд оролцож, сагсан бөмбөг, волейбол, дартс, ширээний теннис, шатар гэсэн спортын 5 төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Увс аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүх, шүүхийн тамгын газрын баг тамирчид дартсын эрэгтэй багийн төрөлд, шатрын эмэгтэй төрөлд тус тус тэргүүн байр, шатрын эрэгтэй төрөлд, сагсан бөмбөгийн эрэгтэй баг тамирчид тус тус гутгаар байр эзэлж амжилтай оролцлоо.



2.2.3.6 Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан жил бүр спортын 5 төрөлт тэмцээн болох Сагс, гар бөмбөг, шатар, ширээний теннис, дартсын тэмцээнийг нийт алба хаагчдын дунд зохион байгуулж байна.

2.2.3.7 Шүүгч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд шүүгч 1, захиргааны 1 албан хаагчийг "Албаны орон сууц эзэмшүүлэх" гэрээ байгуулан албаны орон сууцанд суулгасан,



2.2.3.8 Шүүхийн тамгын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын А/07, 2025 оны 09 дүгээр сарын А/52 дугаар тушаалын дагуу гавьяаны амралтад гарсан нэр бүхий ахмад ажилтанд сарын шинийн баяр болон олон улсын ахмадын баярыг тохиолдуулан санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүндэтгэл үзүүлж байна.

2.2.3.9 Шүүгч, ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад зориулж 10 ширхэг суурин компьютер, Ерөнхий шүүгч, шүүгч нар болон тамгын газрын дарга, шүүхийн захиргааны ажилтнуудын тавилгыг бүрэн шинэчилсэн.

Шүүхийн тамгын газар нь өөрсдийн дотоод нөөцийг ашиглан шинээр жижиг хуралдаан хийх зориулалтаар "шүүх хуралдааны танхим", шүүгч, шүүхийн



захиргааны ажилтны хөгжлийг дэмжих зорилгоор “сургалтын танхим”-ыг засаж тохижуулан ашиглалтад оруулав.

2025 онд шүүгч, ажилтнуудын ажиллах орчин болон иргэд шүүхийн үйлчилгээг ая тухтай орчинд хүргэх зорилгоор шүүхийн байрны 1-3 давхарт их засвар хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд шүүхийн үйлчилгээний болон шүүх хуралдааны танхим, зарим шүүгч, ажилтны өрөөнд засвар хийгдсэн ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тусгай зориулалтын 00-ын өрөө тохижуулсан.

2.2.4 Ёс зүйн дэд хороо, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах

2.2.4.1 Увс аймаг дахь шүүхийн тамгын газар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан шүүхийн тамгын газар нь Ёс зүйн дэд хороог анх 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/43 дугаар тушаалаар байгуулсан. Үүний дараа 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Ёс зүйн дэд хорооны ажиллах журам батлагдсантай холбогдуулан ёс зүйн дүрмийн ёс зүйн дэд хорооны гишүүдийн тоог өөрчлөн Ёс зүйн дэд хороог 2024 оны 05 дугаар сарын А/33 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.

2.2.4.2 Тус шүүхийн Ёс зүйн дэд хороо нь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөөг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр боловсруулан баталж ажиллаж байна.

2.2.4.3 Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Ёс зүйн дэд хорооны мэдээллийн самбар шүүхийн үүдний хэсэгт байршуулсан. Мөн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ахмад, зөвлөх багш М.Мягмаржавыг урьж “Ёс зүй ба ёс суртахуун”,



2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэгийг урьж оролцуулан Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн албан хаагч гэж хэн бэ? сэдвээр сургалтыг зохион байгуулсан болно.

2.2.4.4 Ёс зүйн дэд хорооны гишүүн, шүүгчийн туслах Ц.Энхзаяа “Шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам”-аар сургалтыг 2025 оны 11 сарын 07-ны өдөр зохион байгуулж дараагаар нь танин мэдэхүй, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн



мэдлэгийг бататгах, сорих зорилгоор Шүүхийн захиргаа, үйлчилгээний ажилчдын дунд танин мэдэхүйн “АХА” тэмцээн зохион байгуулсан.

- ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн тамгын газрын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд байгууллагын удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой “А” тушаал 67, шүүхийн хүний нөөцийн удирдлагын чиглэлээр “Б” тушаал 36, нийт 103 тушаал гаргасан байна.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.3-д заасны дагуу Зохион байгуулалтын хэлтсийн дарга 1 /нэг/, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга 4 /дөрөв/, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн 1 /нэг/ сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг холбогдох материалын хамт ШЕЗ-ийн хүний нөөцийн газарт албан бичгээр тус тус хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 22 дугаар тогтоолоор шүүх хуралдааны нарийн бичгийн даргын 3 сул орон тоог нөхөж ажилласан.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсантай холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь хэсэгт заасны дагуу дагуу сонгон шалгаруулж шүүгчийн туслах 4, мэдээлэл лавлагааны мэргэжилтний орон тоон дээр 1 албан хаагчийг тус тус томилсон.

Хүний нөөцийг чадавхжуулах зорилтын хүрээнд Шүүхийн тамгын газрын "Сургалт, судалгааны хороо"-ноос 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 чиглэлийг 13 ажил зохион байгуулахаар төлөвлөж 7 хоног бүрийн 5 дахь өдрийн 17:00 цагийг сургалтын цаг болгосон. Тус сургалтын хүрээнд мэдээлэл технологийн чиглэлээр 4, ёс зүйн дэд хороо соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 3, эрүү, иргэн захиргааны эрх зүйн бодлого бодох аргачлалын хүрээнд 4, ХАСХОМ гаргахад анхаарах асуудлын талаар 1, бусад 4 удаагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.

Тус шүүхийн Тамгын газраас захиргааны ажилтнуудыг мэдлэг чадвараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Үүнд: Шүүгчийн туслах Г.Баярхүү Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн мэргэжлийн магистраар суралцаж төгссөн, нягтлан бодогч А.Мөнхзул “Шихихутуг” их сургуульд, нярав Б.Даваахүү “ИЗОУИС-д эрх зүйн бакалаврын хөтөлбөрт тус тус суралцаж байна.

Шүүхийн захиргааны ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх болон хүний нөөцийн чиглэлээр сургалтыг үе шаттай зохион байгуулснаар ажилтны харилцаа хандлага, иргэд олон нийтэд илтгэл төрүүлэхүйц байдал, ажлын байран дахь ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлж, хувь хүний манлайллыг хөгжүүлэх хүчин зүйл болсон.



2.3.1.6 Албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажлын хүрээнд шүүхээс албадан ирүүлэх 16 захирамж гарч хүргэгдсэнээс 15 яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх ажиллагааг гүйцэтгэж, эрэн сурвалжилсан 10 иргэнээс 3 иргэнийг олж тогтоон ажилласан байна.

2.3.1.7 Шүүгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор анхан болон давж заалдах шатны шүүхийн 9 шүүгчийн өрөө болон 2 зөвлөлдөх тасалгаанд дуудлагын хонх, дуут дохио өгөх хяналтын дэлгэцийг харуулын цагдаагийн хэсэгт байршуулсан. Шүүгчийн амь бие, аюулгүй байдалд халдах болон бусад яаралтай тусламж авах үед хонхыг шүүгч дарснаар харуулын цагдаа цаг, хугацаа алдахгүйгээр дуудлагын дагуу шүүгчийн өрөөнд орж аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.



2.3.1.8 Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд гараагүй.

2.3.1.9 Шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэгт заасан нөлөөллийн мэдүүлгийн талаар хэргийн оролцогч нарт хэрэг үүссэн тухай бүр танилцуулж гарын үсгээр баталгаажуулан хэрэгт хавсаргаж байна.



Иргэдийн төлөөлөгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөх тухай

Мөн шүүхийн иргэдийн төлөөлөгчийн сургалтад нөлөөллийн мэдүүлэг хөтлөх чиглэлээр мэдээлэл тусгасан ба сургалтдаа танилцуулж байна.

2.3.1.10 Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдлого хийсэн тохиолдол гаргаагүй.

2025 онд шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс гомдол, хүсэлт ирүүлээгүй, мөн шүүгч нараас хууль ёсны эрх ашгаа хамгаалахаар шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад хандсан тохиолдол гараагүй байна.

2.3.1.11 Шүүх, шүүгчийн хараат бус, аюулгүй байдлыг хангах, хамгаалах зорилгоор шүүгчийг хуулиар зөвшөөрсөн бие хамгаалах тусгай хэрэгсэл болох цахилгааны бороохойг шүүгч нарт тарааж өгсөн ба хэвийн ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, бүртгэлийн дэвтэр хөтөлж явж байна.



Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх талаар тогтоосон журмыг баримтлан аюулгүй байдлыг хангах, хамгаалах чиглэлээр цагдаагийн байгууллага хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгаж өгсөн байгаа.

Тус шүүхийн тамгын газраас шүүх хуралдаан 17:00 цагаас хойш тарж байгаа тохиолдолд шүүх хуралдаанд орсон бүрэлдэхүүний шүүгч нарыг цагдаагийн хамгаалалттайгаар тухай бүр гэрт нь хүргэж өгч ажилладаг. Энэ онд нийт 35 шүүх хуралдаан 17:00 цагаас хойш үргэлжилсэн байна.

2.3.1.12 2024 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2025 оны 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргуулах бэлтгэл ажлын хүрээнд дотоодын сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Увс аймаг дахь шүүхийн Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан А.Мөнхзул зохион байгууллаа.



2.3.1.13 Шүүхийн үйл ажиллагааны аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийж, тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэхээр тус шүүхийн тамгын газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Шүүхийн үйл ажиллагаанд аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээг хийх холбогдох тайланг 12 дугаар сард багтаан Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэхээр төлөвлөж ажиллаж байна.

2.3.2 Шүүхийн аюулгүй байдлын хүрээнд: Увс аймгийн шүүхийн аюулгүй байдлыг хангах хүрээнд Увс аймгийн Цагдаагийн газраас 4 ээлжээр 24 цагаар шүүхийн байр болон Увс аймаг дахь шүүхийн тамгын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталгаажуулсан шүүхийн хамгаалалтын бүсийн хүрээнд харуулын үүрэг гүйцэтгэж ажиллаж байна.



2.3.2.1 Увс аймгийн цагдаагийн газраас Шүүхийн барилга байгууламж болон түүний гадна орчинд аюулт үзэгдэл, гамшгийн нөхцөл байдал үүссэн үед Цагдаагийн байгууллагын хэв журам сахиулах албанаас ажиллах төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.



2.3.2.2 Шүүхийн байраар үйлчлүүлж буй иргэдэд “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 2.8-д зааснаар шүүхийн тамгын газрын байрны үүдний хэсэгт ачаа тээш түр хадгалах төмөр шүүгээг байрлуулсан бөгөөд шүүхээр үйлчлүүлж буй иргэд түүнд гар цүнх, бусад овор ихтэй эд зүйлсээ хадгалуулан, биеийн байцаалт болон холбогдох баримт бичгээ харуулын цагдаад шалгуулан нэвтэрч байна.

Харуул цагдаа нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, учирч болох гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор 4 ээлжээр 24 цагийн хугацаагаар 320 удаа, жижүүрийн үүрэг гүйцэтгэн ажилласан ба 7260 иргэний баримт бичиг, холбогдох эд зүйлд үзлэг, шалгалт хийн шүүхийн байранд нэвтрүүлэн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Шүүхийн харуул цагдааг согтуурлын зэрэг тогтоох зориулалтын Alcotest 6820 загварын драгер багажаар хангасан ба шүүхээр үйлчлүүлсэн согтууруулах ундаа хэрэглэсэн байж болзошгүй 182 иргэнийг шалгахад спиртийн агууламж 0,20 промилль (%) хэмжээнээс их гарсан 173 иргэний согтолтын зэрэг тогтоож хуралдаанд оруулахгүй, шүүхээр үйлчлүүлэхгүй байх арга хэмжээ авч ажилласан.



ᠮᠤᠩᠭᠡᠨ ᠤᠪᠤᠰ ᠤᠮᠤᠨ ᠰᠢᠷᠭᠡᠨ ᠤᠯᠤᠰ ᠠᠵᠢᠯᠢᠯᠠᠭᠠᠨ ᠲᠠᠢᠯᠠᠩ-2025

2.3.2.3 Гал гарах, цахилгааны гэмтэл үүсэх, ус алдах ямар нэгэн гэмт халдлага болон эрсдэл бүхий онцгой нөхцөл байдал үүссэн шаардлагатай үед ашиглах зорилгоор шүүгч, ажилтнуудын өрөө, архив, сервер шүүх хуралдааны танхим, болон бусад **өрөөний бүх цоожны голыг сольж** нөөц түлхүүрийг бүрдүүлж, “Нөөц түлхүүрийн хайрцаг” байршуулан ажиллаж байна. Нөөц түлхүүр ашиглах тохиолдол бүрт бүртгэлийн дэвтэр бүртгэж тамгын газрын даргын зөвшөөрлөөр олгогдож байна.



2025 онд нийт 35 ширхэг лац, тэмдэг, суурийг Улаанбаатар хотод “Ган лац” ХХК-аар шинээр хийлгэж шүүгч, ажилтнуудад нэг бүрчлэн хариуцуулж, лацны суурь тэмдгийг шинэчиллээ.




| №  | Хүний нэр     | Тамгын газрын үйл ажиллагааны тайлан-2025 |
|----|---------------|---|
| 1  | Сүхбаатар 100 |   |
| 2  | Сүхбаатар 100 |   |
| 3  | Сүхбаатар 100 |   |
| 4  | Сүхбаатар 100 |   |
| 5  | Сүхбаатар 100 |   |
| 6  | Сүхбаатар 100 |   |
| 7  | Сүхбаатар 100 |   |
| 8  | Сүхбаатар 100 |   |
| 9  | Сүхбаатар 100 |   |
| 10 | Сүхбаатар 100 |   |
| 11 | Сүхбаатар 100 |   |
| 12 | Сүхбаатар 100 |   |
| 13 | Сүхбаатар 100 |   |
| 14 | Сүхбаатар 100 |   |
| 15 | Сүхбаатар 100 |   |
| 16 | Сүхбаатар 100 |   |
| 17 | Сүхбаатар 100 |   |
| 18 | Сүхбаатар 100 |   |
| 19 | Сүхбаатар 100 |   |
| 20 | Сүхбаатар 100 |   |
| 21 | Сүхбаатар 100 |   |
| 22 | Сүхбаатар 100 |   |
| 23 | Сүхбаатар 100 |   |
| 24 | Сүхбаатар 100 |   |
| 25 | Сүхбаатар 100 |   |
| 26 | Сүхбаатар 100 |   |
| 27 | Сүхбаатар 100 |   |
| 28 | Сүхбаатар 100 |   |
| 29 | Сүхбаатар 100 |   |
| 30 | Сүхбаатар 100 |   |
| 31 | Сүхбаатар 100 |   |
| 32 | Сүхбаатар 100 |   |
| 33 | Сүхбаатар 100 |   |
| 34 | Сүхбаатар 100 |   |
| 35 | Сүхбаатар 100 |   |

Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын өрөө болон хэргийн эд мөрийн баримт хадгалах өрөө, сервер, архивын өрөөг ажил тарсны дараа лац дарсан эсэхийг цагдаагийн ажилтан шалгаж, лац хүлээлцсэн актад шүүгч ажилтнуудаар гарын үсэг зуруулж, тамгын газрын даргад өдөр бүр танилцуулж байна.

2.3.2.4 Шүүх хуралдааны дэг сахиулагч цагдаагийн алба хаагч нь тухайн өдрийн шүүх хуралдаан эхлэхээс өмнө шүүх хуралдааны танхим /шүүх хуралдаан хийх шүүхийн байрнаас бусад газар/-д орж, танхимын аюулгүй байдлыг **2295** шүүх хуралдаанд дээрх арга хэмжээ авч ажилласан.

2.3.2.5 Шүүхийн байрны дотор талд 14, гадна 6 нийт 20 хяналтын камераар шүүхийн байрыг 7 хоногийн 24 цагаар тасралтгүй харуул цагдаагийн албан хаагчийн ширээнд байрлуулсан дэлгэцээр тогтмол хяналт тавин ажиллаж байна.



Үүнээс тодруулбал яллагдагч, шүүгдэгч, ялтныг тусгаарлах өрөө, архивын өрөө, серверийн өрөө, эд мөрийн баримтын өрөө, өмгөөлөгч нарын өрөөнүүдэд хяналтын камер суурилуулсан болно.



2.3.2.6 Тус шүүхийн галын аюулгүй байдлын хүрээнд архивын өрөөнд халуун мэдрэгчтэй автомат галын хор 2 ширхэг, гар ажиллагаатай шүршдэг хор 1 ширхэг, эд мөрийн баримтын өрөө болон серверийн өрөөнд тус тус байрлуулсан.



2.3.2.7 Шүүхийн галын аюулгүй байдлын хүрээнд Увс аймгийн Онцгой байдлын газраар 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр галын аюулгүй байдлын 0022344 дугаар дүгнэлт гарсан.

2.3.2.8 2025 онд шүүхэд сахилга хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг дээшлүүлэх зорилгоор нийтээр тэмдэглэх баярын өдрүүд болох Монголын уламжлалт цагаан сар, Үндэсний их баяр наадам болох Улсын баяр наадмаар хариуцлагатай жижүүр томилж ажилласан. 2024.02.27 №А/11 тушаал, 2025.07.08 №А/44 тушаал

• ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн тамгын газар нь Хууль зүй дотоод хэргийн сайд, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны А/116, 65 дугаартай хамтарсан тушаалаар баталсан "Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам"-ын хэрэгжилтийг хангах үүднээс Увс аймгийн цагдаагийн газартай 2025 онд "Хамтран ажиллах төлөвлөгөө", "Онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах төлөвлөгөө"-г 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр байгуулан ажилласан.

Тус төлөвлөгөөнд 32 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж төлөвлөгөөний хэрэгжилт 96.8 хувьтай байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны А/116/65 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ын хүрээнд Увс аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хангах тасгаас Увс аймаг дахь анхан болон



давж заалдах шатны шүүх дээр шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн ахлагч офицер-1, дэг сахиулагч цагдаа-2, харуул цагдаа-4 нийт 7 албан хаагч үүрэг гүйцэтгэн ажиллалаа.

2025 онд 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар шүүхийн дэг сахиулагч цагдаа нь Увс аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд зөрчлийн 93, иргэний 43, эрүүгийн 73, Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд захиргааны 107, Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд зөрчлийн 895, иргэний 629, эрүүгийн 455 шүүх хуралдаан дэг сахиулсан ба нийт 2295 удаагийн шүүх хуралдаан дэг сахиулсан байна.

“Яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах журам”-ын 2.12, 4.1, 5.1 дэх хэсгүүдэд зааснаар шүүхээс цагдан хорих байранд 222, цагдан хорих байрнаас шүүхэд 159 ялтан, шүүгдэгчийг хуяглан хүргэж ажилласан.

Шүүгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор анхан болон давж заалдах шатны шүүхийн 9 шүүгчийн өрөө болон 2 зөвлөлдөх тасалгаанд дуудлагын хонх, дуут дохио өгөх хяналтын дэлгэцийг харуулын цагдаагийн хэсэгт байршуулсан. Шүүгчийн амь бие, аюулгүй байдалд халдах болон бусад яаралтай тусламж авах үед хонхыг шүүгч дарснаар харуулын цагдаа цаг, хугацаа алдахгүйгээр дуудлагын дагуу шүүгчийн өрөөнд орж аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Увс аймгийн шүүхийн аюулгүй байдлыг хангах хүрээнд Увс аймгийн Цагдаагийн газраас 4 ээлжээр 24 цагаар шүүхийн байр болон Увс аймаг дахь шүүхийн тамгын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталгаажуулсан шүүхийн хамгаалалтын бүсийн хүрээнд харуулын үүрэг гүйцэтгэж ажиллаж байна.

Харуул цагдаа нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, учирч болох гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор 4 ээлжээр 24 цагийн хугацаагаар 320 удаа, жижүүрийн үүрэг гүйцэтгэн ажилласан ба 7260 иргэний баримт бичиг, холбогдох эд зүйлд үзлэг, шалгалт хийн шүүхийн байранд нэвтрүүлэн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Гал гарах, цахилгааны гэмтэл үүсэх, ус алдах ямар нэгэн гэмт халдлага болон эрсдэл бүхий онцгой нөхцөл байдал үүссэн шаардлагатай үед ашиглах зорилгоор шүүгч, ажилтнуудын өрөө, архив, сервер шүүх хуралдааны танхим, болон бусад өрөөний бүх цоожны голыг сольж нөөц түлхүүрийг бүрдүүлж, “Нөөц түлхүүрийн хайрцаг” байршуулан ажилласан.

Шүүхийн байрны дотор талд 14, гадна 6 нийт 20 хяналтын камераар шүүхийн байрыг 7 хоногийн 24 цагаар тасралтгүй харуул цагдаагийн албан хаагчийн ширээнд байрлуулсан дэлгэцээр тогтмол хяналт тавин ажиллаж байна.

## 2.4 ШҮҮХИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

**2.4.1 Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд батлагдсан цалингийн сан, орон тоонд багтаан төсвийн хөрөнгийг удирдах, батлагдсан төсвийг зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай зарцуулах, бүртгэх, тайлагнахад хяналт тавих талаар**

Шүүхийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах чиг үүргийнхээ хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 онд баталсан “Бүтэц, орон тооны хязгаар, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” 76,101 дүгээр тогтоолуудыг үндэслэн анхан болон давж заалдах шатны шүүхийн 9 шүүгч, шүүхийн Тамгын газрын захиргааны 28 орон тоотойгоор ажиллаж байна.

2025 онд 2,982,5 сая төгрөгийн төсөв анх батлагдаж тодотголоор 14,6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.



2025 оны 10,11 дүгээр саруудад нийт 80,2 сая төгрөгийн санхүүжилтийг сангийн яамнаас татсан бөгөөд цалингийн сангаас бусад бүх зардал 00 үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсвийг хөтөлбөр зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан бөгөөд сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын дагуу эдийн засгийн ангиллаар ажил гүйлгээг хийсэн болно.

2025 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр 2,574.1 сая төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал мөн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт төсвийн 87,6 хувь буюу 2,253.7 сая төгрөгийг, бусад урсгал зардалд 12,4 хувь буюу 317,4 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал:** 2025 оны 11 сарын байдлаар цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 2,006.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс 9 шүүгчид олгосон цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 826,9 сая төгрөг буюу нийт цалингийн сангийн 41,2 хувийг, төрийн захиргааны 18 албан тушаалтнуудад 796,4 сая төгрөг буюу 40 хувийг, 10 төрийн үйлчилгээний албан тушаалтнуудад 382,7 сая төгрөг буюу 18,8 хувийг зарцуулсан болно.

Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй төрийн үйлчилгээний албан хаагч нарт улирал бүр ажлыг дүгнэж 18,4 сая төгрөгийн, төрийн захиргааны албан тушаалтнуудад хагас жилээр 38,1 сая төгрөгийг олгосон.

Анхан шатны шүүгч нарт ачааллын нэмэгдэл 22 сая төгрөгийг хагас жилээр олгосон. Сар бүр цалин хөлсийг Төрийн албаны цалингийн [www.payroll.gov.mn](http://www.payroll.gov.mn) нэгдсэн системээр тооцон олгож байна.

#### **Бараа үйлчилгээний бусад зардлын тухайд:**

**Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал:** 11 сарын байдлаар нийт төсвийн 4 хувь буюу 98 сая төгрөгийг тогтмол зардалд зарцуулсан бөгөөд сангийн яамнаас төсөв татсаны улмаас түлш халаалтын зардалд 11.2 сая төгрөгийн өртэй гарсан.

**Хангамж бараа материалын зардал:** Нийт төсвийн 3,3 хувь буюу 85,8 сая төгрөгийн төсөв зарцуулсан бөгөөд 10,11 саруудад төсөв олгоогүйн улмаас 12 сая төгрөгийн өр үүсээд байна. Шуудан холбооны зардлын үнэ тариф өссөнтэй холбоотой зардал өндөр гарч байна. Мөн шүүхэд ирэх хэрэг маргааны тоо нэмэгдсэнээр шүүн таслах ажиллагаатай холбоотой зардлууд ихээр нэмэгдсэн.

**Норматив зардал:** Нормын хувцас зөөлөн эдлэл авах зардлаас энэ онд “Шилмэл загвар” ХХК-аас 1 шүүгчид нөмрөг авсан. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу зөвхөн шүүгч нарын өмсгөлийг олгож байна.

**Эд хогшил урсгал засварын зардал:** Энэ онд нийт төсвийн 0,8 хувь буюу 21,2 сая төгрөгийн төсөв зарцуулсан байна. Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын дагуу эдийн багаж техник хэрэгслийн зардлаас байгууллагад нэн шаардлагатай техник хэрэгслийг цөөн тоогоор авна гэж заасны дагуу принтер, сүлжээний свич, тоос сорогч гэх мэт нийт 8,9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн.

Урсгал засварын зардлаас өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангах үүднээс халаалттай холбоотой дулаалгын материал авах мөн автомашины сэлбэг хэрэгсэл худалдан авахад нийтдээ 12,3 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ онд дастер автомашинд шаардлагатай байгаа сэлбэгийг Моннис ХХК-аас 4 сая төгрөгөөр худалдан авч тавилаа.

Мөн Прадо-150 машинд 700000 төгрөгөөр радиатор авч тавьсан.

**Томилолт, зочны зардал:** Нийт төсвийн 1 хувь буюу 24,7 сая төгрөгийг зарцуулсан байна. Увс аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны

шүүхийн 1 шүүгчийн орон тоо сул байгаа учраас зэргэлдээх 2 аймгаас шүүх бүрэлдэхүүн дуудаж шүүх хурал хийж байна.

Сард 2-3 удаа шүүх бүрэлдэхүүн авч байгаа бөгөөд шүүгч жолоочийн томилолт, зочид буудлын зардалд нэг удаа ирэхэд 420000 төгрөг зарцуулж байна.

2025 оны 11 сарын байдлаар 16 удаа давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн авсан мөн Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх болон Захиргааны хэргийн анхан шатны шүүх нийтдээ 9 удаа зэргэлдээх аймгаас шүүх бүрэлдэхүүн авсан байна. Мөн шүүх хуралд иргэдийн төлөөлөгчөөр оролцохоор сумаас сонгогдсон иргэдэд томилолт олгож байна.

10 дугаар сард нийт шүүгч нарын чуулганд оролцсон 9 шүүгчид томилолтын 6 сая төгрөгийн томилолтын зардал олгосон байна.

**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал:** 11 сарын байдлаар олгосон нийт төсвийн 0,2 хувь 4,8 сая төгрөгийг зарцуулсан. Байгууллагын автомашины төлбөр хураамж даатгал, аудитын баталгаажуулалт газрын төлбөр зэрэг зардлуудыг төлж барагдуулсан байна.

**Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал:** Нийт төсвийн 0,6 хувь буюу 16 сая төгрөгийг зарцуулсан байна. Шүүхийн ахмад настнуудад цагаан сарын баяр болон ахмадын өдрүүдэд хүндэтгэл үзүүлсэн мөн шүүхийн нярваар ажилласан байсан ажилтан эрүүл мэндийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн тул хөдөлмөрийн хуулийн дагуу тэтгэмж олгосон байна.



**Шинжээч орчуулагч хэлмэрчийн зардал:** Нийт төсвийн 0,1 хувь буюу 3 сая төгрөгийг зарцуулаад байна.

Сум дундын анхан шатны шүүхэд гэр бүл цуцлуулахаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд хүүхдийг аав ээжийн аль нэгний асрамжид үлдээхийн тулд нөхцөл байдлын үнэлгээ хийдэг. Уг үнэлгээг мэргэжлийн байгууллага хийдэг бөгөөд тухай үйл ажиллагааг хийхийн тулд эхлээд шүүхээс бүх зардлыг гаргаж хэрэг эцэслэн шийдвэрлэсний дараа зохигчоос төлбөрийг гаргуулж шүүхийн Тамгын газрын дансанд буцаан төлдөг. Энэ үнэлгээг гаргуулахын тулд 9 сарын байдлаар шинжээч орчуулагчийн зардалд 2.6 сая төгрөгийн авлага үүсээд байна.

**2.4.2 Шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн төслийг бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, стандартын дагуу үндэслэлтэй боловсруулах, холбогдох байгууллагад хүргүүлэх, шийдвэрлэх**

Шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын 2026 оны төсвийн төслийн саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санхүү хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн заавар маягтын дагуу бодит хэрэгцээ шаардлага, норм стандартын дагуу үндэслэлтэй боловсруулж, хуулийн хугацаанд албан бичиг төсвийн саналын хамт хүргүүлсэн болно.





Увс аймаг дахь шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны тайлан-2025

### 2.4.3 Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг иж бүрэн, үнэн зөв, хуульд заасан хугацаанд гаргах талаар

Шүүхийн Тамгын газрын 2025 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу үнэн зөв иж бүрэн гарган <http://old-ereport.mof.gov.mn/EReport/> цахим санхүүгийн тайлангийн системд шивж нэгтгүүлдэг. Төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, авлага өглөгийн мэдээг сар бүрийн 2-ны дотор гарган санхүү хөрөнгө оруулалтын газар болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлдэг болно. Мөн сар бүр цалингийн мэдээг шүүгч, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч тус бүрээр гарган санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж байна.

### 2.4.4 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллана.

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан маягт зааврын дагуу анхан шатны бүртгэлийн маягтыг хөтлөн санхүүгийн тайлан мэдээг үнэн, зөв иж бүрэн тайлагнадаг. Сангийн сайдын 2023 оны 211 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын дагуу ажил гүйлгээг ямар нэгэн зөрчил гаргахгүйгээр хийж хэвшсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална гэсний дагуу архивд хадгалж байна.



### 2.4.5 Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах

Өмч хамгаалах байнгын зөвлөл 2025 оны ажлын төлөвлөгөө боловсруулж Тамгын газрын даргаар батлуулдаг.

Төлөвлөгөөний дагуу дэс дараатайгаар хуулийн хугацаанд төлөвлөсөн ажлаа хийсэн байна. 2026 оны төсвийн төсөлд байгууллагад шаардлагатай дутагдалтай байгаа хөрөнгийн судалгаа гаргаж дэлгэрэнгүй танилцуулгатай хүргүүлсэн.

Эд хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр явуулж, үндсэн болон эргэлтийн хөрөнгө хариуцсан нярвын тооцоог хөрөнгийн ангилал тус бүрээр бодож, актаар баталгаажуулж, санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж байна. 2025 оны 3 сард нярвын ажил хүлээлцэхэд даргын тушаалаар тооллогын комисс томилж хөрөнгө материалыг нэг бүрчлэн тоолж авсан.



Албаны 2 орон сууцанд 1 шүүгч, 1 шүүхийн захиргааны ажилтан амьдарч байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 86 дугаар тогтоолын дагуу гэрээ байгуулж орон сууцыг эзэмшигчээр хөрөнгийн даатгалд даатгуулсан болно.

**2.4.6 Үндсэн хөрөнгө олж авах, балансаас баланст шилжүүлэх, ашиглалтын хугацаа дууссан, хугацаа дуусаагүй боловч цаашид ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах, шилжүүлэх эсхүл худалдах санал, холбогдох материалыг бүрдүүлэн, Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрлөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх, шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, эд хөрөнгийн бүртгэх, тайлагнах үйл ажиллагаанд хяналт тавих**

11 сарын байдлаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 3,8 сая төгрөгийн үнэ бүхий суурин компьютерийг мэдээлэл технологийн ажилтанд, 4 шүүгч 16 шүүхийн захиргааны ажилтнуудад нийт 63,2 сая төгрөгийн тавилга эд хогшил шилжүүлэн өгсөн. Багаж техник хэрэгсэл удалдан авах зардлаас 899900 төгрөгийн тоос сорогч, 151000 төгрөгийн ном, 2 ширхэг принтер сүлжээний свичүүдийг худалдан авч НББОУС-ын дагуу бүртгэл хөтлөн тайлагнасан. ТӨБЗГ-ын 271 дүгээр тогтоолын 4.1.1-д зөвшөөрөл авах шаардлагагүй гэж заасан тул шууд худалдан авалт хийсэн.

2025 оны 9 сард ТӨБЗГ-ын 271 тоот тогтоолд заасны дагуу баримтыг бүрдүүлж, хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоолгох мөн элэгдлээ бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг актлах, балансаас балансанд шилжүүлэх хөрөнгийн саналыг тус тус хүргүүлсэн. Үндсэн хөрөнгийн тайлан мэдээг УСНБОУС 16-д нийцүүлэн бүртгэж тайлагнадаг.

Төрийн болон Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-ийг нэвтрүүлэх ажлын хүрээнд [www.umch.sgov.mn](http://www.umch.sgov.mn) системд хөрөнгийн хөдлөлийг хийж, хөрөнгийн зургуудыг нэг бүрчлэн оруулан бэлтгэл ажлыг иж бүрэн хангасан болно.

Энэ онд шүүхийн ерөнхий зөвлөлөөс худалдан авах ажиллагааг зохион байгуулж 400 сая төгрөгөөр шүүхийн барилгын дотор их засварын ажлыг гүйцэтгэж, ашиглалтад бүрэн оруулсан.

Тус засварын ажлын зураг төслийг “Оюусувд дэлгэрэх” ХХК, ажлын гүйцэтгэгчээр “Мөнхийн ундраа Увс” ХХК ажиллаж засварын ажлыг гүйцэтгэсэн.



Шүүхийн 3 давхар барилгын ашиглалтын нөхцөлийг сайжруулах, интерьерийн шийдлийг шинэчлэх, тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор дараах дотор засварын ажил хийхээр төлөвлөгдсөн.



ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠤᠨᠳᠠᠷᠠᠭ ᠤᠪᠤᠰ



Засварын хүрээнд хийсэн онцлог ажил нь шүүхээр үйлчлүүлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тусгай зориулалтын 00-ын өрөө тохижууллаа.



**2.4.7 Төрийн албаны цалингийн системээр бодогдсон цалин, ажилчдын цалин болон татвар, эрүүл мэнд нийгмийн даатгалын тайлангийн уялдааг хангах, тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв хийж, өр, авлагагүй ажиллах талаар**

Төрийн албаны цалингийн нэгдсэн [www.payroll.gov.mn](http://www.payroll.gov.mn) системд цалин хөлсний тооцоолол хийснээр даатгуулагч, ажил олгогчоос төлөх шимтгэлийн дүн, нийгмийн даатгалын [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) цахим системд оруулсан цалингаас тооцсон шимтгэлийн дүн тэнцэж байгаа эсэхийг байнга тулган баталгаажуулж байж төлөлт хийж байна. НДШ-ийн цахим программаас НД-8, НД-7 тайлан мэдээг хэвлэн авч гарын үсгээр баталгаажуулан цахимаар болон цаасаар харьяа нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлдэг.

Төрийн албаны цалингийн нэгдсэн системд цалин хөлсний тооцооллыг хийснээр төлөх ХХОАТ-ын дүн, улирал бүр татварын [etax.mn](http://etax.mn) цахим программын дүнтэй таарч байгаа эсэхийг хянан баталгаажуулдаг. Тооцооллын алдаа гардаггүй. Жилийн эцэст ХХОАТ-ын хөнгөлөлтийн зөрүү байгаа эсэхийг цалингийн программ дээр дахин тооцоолж зөрүү үүссэн тохиолдолд тухайн хүнээс суутгах эсвэл буцаан олгодог байгаа. 11 сарын байдлаар өр авлага үүсээгүй болно.

**2.4.8 Төрийн цахим худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтыг ашиглан, ил тод, нээлттэй байлгаж, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажилласан талаар**

Тухайн онд худалдан авах бараа материал, хөрөнгө, засварын ажлын төлөвлөгөөг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системд шивж ШЕЗ-ийн худалдан авах



үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомж дүрэм зааврыг санхүүгийн үйл ажиллагаандаа даган мөрдөж ажилласан.

Цаашид шүүхийн тамгын газраас санхүү, эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр ажиллахдаа өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор ажиллаж ирснийг хадгалах:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд сахин, хэмнэлтийн горимыг баримталж зохион байгуулж байгаа ажлыг аль болох бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байдлаар хийж гүйцэтгэх,

Шүүгч шүүхийн захиргааны ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэх үүднээс нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгох зардлын төсвийг төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлан нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллах,

Шүүхийн захиргааны ажилтнуудад орон нутагт ажилласны 80 хүртэлх хувийн нэмэгдлийг олгох талаар орон нутгийн удирдлагуудад танилцуулж орон нутгаас санхүүгийн дэмжлэг авах,

Хурал семинар уулзалт зөвлөгөөнийг аль болох цахим хэлбэрээр зохион байгуулах, шаардлагатай материалыг цахим хэлбэрээр тараах,


Худалдан авах ажиллагааг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа нь сайшаалтай бөгөөд цаашид принтерийн хор бичгийн цаас гэх мэт өргөнөөр хэрэглэдэг материалыг цахим системд оруулах талаар уламжлан ажиллах болно.

## 2.5 МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.5.1 Шүүхийн тамгын газар нь үйл ажиллагааны эрхэм зорилго, танилцуулга, бүтэц зохион байгуулалт, төсөв санхүү, шилэн данс, аудитын дүгнэлт, ёс зүйн дүрэм хэрэгжилтийн талаарх мэдээллийг шүүхийн үйлчилгээний хэсэг дэх мэдээллийн самбарт шинэчлэн байршуулж шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна.



2.5.2 Мөн [www.court.uv.gov.mn](http://www.court.uv.gov.mn) домайн хаяг бүхий цахим хуудас болон Увс аймаг дахь шүүхийн Тамгын газар Facebook хуудсыг шүүхийн өдөр тутмын үйл ажиллагаа, шүүх хуралдааны тов, тойм, нэхэмжлэл өргөдлийн загвар болон бусад мэдээ мэдээллийг, чатбот иргэдэд түгээн тогтмол ажиллуулж байна.



Тус сайтад анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн танилцуулга, 2025 онд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол хүлээн авах шүүгчдийн зөвлөгөөний

тогтоол, шүүхэд хэрхэн хандах, шүүхэд нэхэмжлэл гаргахад бүрдүүлэх материал болон улсын тэмдэгтийн хураамжийн дансны талаарх мэдээлэл, шүүх хуралдааны тов, тойм, шүүхийн тамгын газрын ажилтнуудтай холбоо барих утасны дугаар зэргийг байршуулж мэдээллийг түгээн, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар цаг үеийн шинжтэй 89 мэдээлэл байршуулан ажилласан.

2.5.3 Увс аймгийн анхан болон давж заалдах шатны шүүх шүүхийн шийдвэр болон процессын 4 тойм,

The screenshot displays the website of the Uvsvaykhag (Uvsvaykhag) with the following content:


- Header:** УВС АЙМАГ ДАХЬ АНХАН БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ. Давсагаас Баасан гараг хүртэл - 08-12 цагаас 13-17 цаг. 70454570.
- Navigation:** Нүүр, Иргэн Танд, Хэрэг Хуваарилах Журам, Шүүхүүд, Тамгын Газар, Эвлэрүүлэн Зуучлагч, Шилэн Данс.
- Main Section:** ШИЙДВЭРИЙН ТОЙМ
- Case 1:** БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛДААН БАГИЙН ЗАСАГ ДАРГЫГ СОНГОХ САНАЛ ХУРААЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭХ ЭРХТЭЙ. 2025-09-12 00:00:00. Дэлгэрэнгүй.
- Case 2:** БАГШ, АЖИЛТАН МӨНГӨН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМД ЗААСНААС ӨӨР ҮНДЭСЛЭЛЭЭР АЖЛААС ЧӨЛӨӨ АВСАН ХУГАЦААГ ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАСАН ХУГАЦААНД ТООЦОХГҮЙ. 2025-09-12 00:00:00. Дэлгэрэнгүй.
- Case 3:** СОНГОГЧДЫН САНАЛЫГ ТАТАХ ЗОРИЛГООР СОНГУУЛИЙН ЖИЛД ХОНЖВОРТ СУГАЛАА ЗОХИОН БАЙГУУЛСАН НЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР ТОГТООГДСОН БАЙХЫГ ШААРДАНА. 2025-01-03 00:00:00. Дэлгэрэнгүй.
- Search:** Хайлт
- Хэрэгцээт Холбоос:** Шүүхийн Ерөнхий Сөвлөл, Улсын Дээд Шүүх, Шүүхийн Шийдвэрийн Цахим Сан, Шүүхийн Хуралдааны Явцын Систем.

2.5.4 Анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт 56 удаагийн цахим шууд дамжуулалт,



2.5.5 13 удаагийн шүүх хуралдааныг бичлэг,

2.5.6 Увс аймаг дахь шүүхийн тамгын газрын 2023, 2024 оны үйл ажиллагааны бүтэн жилийн тайлан, [www.court.uv.gov.mn](http://www.court.uv.gov.mn) байршуулсан.



**УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025-01-09 00:00:00 дэлгэрэнгүй

Хайлт

**Хэрэгцээт Холбоос**

- Шүүхийн Ерөнхий Зөвлөл
- Улсын Дээд Шүүх
- Шүүхийн Шийдвэрийн Цохим Сөн
- Шүүхийн Хуралдааны Явцын Систем



**УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2.5.7 Увс аймаг дахь анхан болон давж заалдах шатын шүүхийн 2024 оны шүүн таслах ажиллагааны бүтэн жилийн мэдээ, 2025 оны 1 дүгээр улирлын мэдээг зурган хэлбэрээр постер хэлбэрээр олон нийтэд хүргэлээ.



2.5.8 Тамгын газрын ажилтнуудтай холбоо барих утасны дугаарыг улирал бүр шинэчлэн байршуулж байна.

УВС АЙМАГ ДАХЬ АНХАН БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ТУСЛАХУУДЫН И-МЭЙЛ ХАЯГ, УТАСНЫ ДУГААР  
2025.05.01

| Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх |               |                                 |                           |                    |
|---|---------------|---------------------------------|---------------------------|--------------------|
| №   | Шүүгч         | Шүүгчийн туслах                 | И-Мэйл хаяг               | Утасны дугаар      |
| 1   | Л.Алтан       | Ш.Анхцэцэг                      | davakh.690.eit@shuukh.mn  | 99675686           |
| 2   | Н.Мөнхжаргал  |                                 |                           |                    |
| Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх                |               |                                 |                           |                    |
| 1   | Б.Гансүх      | Д.Нямгэрэл                      | ankhan.686.et@shuukh.mn   | 99954048           |
|   |               | Б.Сарантуяа                     | ankhan.687.et@shuukh.mn   | 88065889           |
| 3   | Б.Мөнхзаяа    | Д.Нямжав                        | ankhan.688.et@shuukh.mn   | 92035955           |
| 4   | П.Болор       | Т.Жаргалсайхан                  | ankhan.683.it@shuukh.mn   | 88023847           |
| 5   | Л.Дэлгэрцэцэг | Б.Энхтуяа                       | ankhan.684.it@shuukh.mn   | 99591330           |
| 6   | Я.Урнаа       | Г.Баярхүү                       | ankhan.685.it@shuukh.mn   | 96095111           |
| Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх        |               |                                 |                           |                    |
| 1   | Д.Алтанцэцэг  | Б.Байгалмаа                     | ankhan.689.zt@shuukh.mn   | 89387028           |
| 2   | О.Батдорж     | Ц.Энхзаяа                       |                           | 80015588           |
| Увс аймаг дахь шүүхийн Тамгын газар                       |               |                                 |                           |                    |
| №   | Овог нэр      | Албан тушаал                    | И-Мэйл хаяг               | Утасны дугаар      |
| 1   | Б.Доржсүрэн   | Хэлтсийн дарга                  | dorjsuren.court@gmail.com | 70452290, 89250536 |
| 2   | Н.Мөнхтөр     | Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн | munkhturnyamjav@gmail.com | 70454570, 86669663 |
| 3   | Б.Одонтуяа    | Архив, бичиг хэрэг              | uvs_tg@shuukh.mn          | 94467735           |
| 4   | С.Уранчимэг   | Эвлэрүүлэн зуучлагчийн туслах   | ez.35@shuukh.mn           | 70454063, 85545066 |

2.5.9 Увс аймаг дахь шүүхийн тамгын газрын зохион байгуулалтын хэлтсийн дарга Б.Доржсүрэн нь 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр “Увс телевиз”-д Увс аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх, Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 онд хянан шийдвэрлэсэн, эрүү, иргэн, захиргаа хэргийн тоон мэдээлэл болон зөрчил, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх мэдээллийг танилцууллаа.



2.5.10 Шүүхийн үйл ажиллагааг нээлттэй сурталчлах мэдээллээр хангах олон нийтийг чиглэсэн арга хэмжээний хүрээнд болон тус шүүхийн тамгын газраас нээлттэй хаалганы өдөрлөг 2025 оны 5 дугаар сарын 01-ны өдөр иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх “Хуульчийн Про Боно өдөр-2025” өдөрлөг, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Увс аймгийн Улаангом сумын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс санаачлан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Нээлттэй өдөрлөг”-ийг тус тус зохион байгууллаа.




2.5.11 Увс аймгийн Өлгий, Өмнөговь, Ховд, Бөхмөрөн, Завхан Наранбулаг сумуудад шүүхийн үйл ажиллагаа, shuukh.mn, эвлэрүүлэн зуучлал, Шүүхийн иргэдийн төлөөлөгчид зориулсан сургалт,



2.5.12 Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Алтанцэцэг, Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, 3 дугаар сургууль, 4 дүгээр сургуулиудад шүүхийн үйл ажиллагаа, шүүгчийн ажлын онцлогийн талаарх сургалт, ярилцлага,



2.5.13 Увс аймгийн Улаангом сумын 4 дүгээр сургуулийн 8 болон 10 дугаар ангийн төлөөлөл болсон сурагчид анхан болон давж заалдах шатны шүүх, шүүхийн тамгын газрын үйл ажиллагаатай танилцууллаа.




Уг танилцуулгаар монгол улсын шүүхийн тогтолцоо, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны талаар ойлголт, мэдлэг олгохыг зорилоо. Мөн шүүх хуралдааны танхим, мэдээлэл лавлагааны хэсгээр зочилж, сурагчдын сонирхсон асуултад хариулт өгснөөр сурагчид практик мэдлэгээ батжуулж байгаадаа шүүхийн байгууллагад талархлаа илэрхийллээ.


2.5.14 Увс аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Б.Гансүх Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн сурагчдад “Цахим орчны зохистой хэрэглээ” сэдвээр сургалт тус тус зохион байгууллаа.



2.5.15 Шүүхийн [www.court.uv.gov.mn](http://www.court.uv.gov.mn) домайн хаяг бүхий цахим хуудас болон Увс аймаг дахь шүүхийн Тамгын газар Facebook хуудсыг шүүхийн өдөр тутмын үйл ажиллагаа, шүүх хуралдааны тов, тойм, мэдээ мэдээллийг, мэдээллийн самбарт нэхэмжлэл өргөдлийн загвар байршуулж бусад мэдээ мэдээллийг 7 хоног бүр мэдээллийн самбарт шинэчлэн байршуулж байна.



2.5.16 Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмын хүрээнд 2025 оны Увс аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт 1191 шийдвэр, шийтгэх тогтоол, магадлалыг <https://shuukh.mn> сайтад байршуулаад байна.



2025 оны анхны сурталчилгаа



Иргэдийн төлөөлөгчийн оролцоо, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нэгдсэн мэдээллийг улирал бүр цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах, тухай бүр шинэчлэн байршуулж байна.

Шүүхийн үйлчилгээний төвд шүүхээр үйлчлүүлэх иргэдэд зориулан төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” киоск машиныг байршууллаа. Тус киоск машиныг байршуулснаар “Иргэд шүүхээр үйлчлүүлэхэд цаг хугацаа алдахгүй, нэг цэгээс үйлчилгээ авах боломж бүрдэхийн зэрэгцээ улсын тэмдэгтийн хураамж төлөх, төр, хувийн хэвшлийн 60 байгууллагын 600 гаруй үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай авах боломжтой бүрдсэн.



Зураг: Төрийн үйлчилгээний “Хурдан” болон “Гэрээ” киоск машины бодит зураг болон зааврын хамт

### • ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байх зарчмыг хангах, иргэн төвтэй шүүхийн үйлчилгээг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим систем ашиглан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллээр иргэд, олон нийтийг түргэн шуурхай хангах зорилгоор Увс аймаг дахь шүүхийн Тамгын газар Facebook цахим хуудас болон court.uv.gov.mn вэб сайтуудыг ажиллуулж байна.

Шүүхийн үйл ажиллагааг нээлттэй сурталчлах мэдээллээр хангах олон нийтийг чиглэсэн арга хэмжээний хүрээнд болон тус шүүхийн тамгын газраас нээлттэй хаалганы өдөрлөг 2025 оны 5 дугаар сарын 01-ны өдөр иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх “Хуульчийн Про Боно өдөр-2025” өдөрлөг, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Увс аймгийн Улаангом сумын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс санаачлан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Нээлттэй өдөрлөг”-ийг тус тус зохион байгууллаа.

Увс аймгийн Өлгий, Өмнөговь, Ховд, Бөхмөрөн, Завхан Наранбулаг сумуудад шүүхийн үйл ажиллагаа, shuukh.mn, эвлэрүүлэн зуучлал, Шүүхийн иргэдийн төлөөлөгчид зориулсан сургалтыг,

Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Алтанцэцэг, Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, 3 дугаар

сургууль, 4 дүгээр сургуулиудад шүүхийн үйл ажиллагаа, шүүгчийн ажлын онцлогийн талаарх сургалт, ярилцлагыг,

Увс аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Б.Гансүх Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн сурагчдад “Цахим орчны зохистой хэрэглээ” сэдвээр сургалт тус тус зохион байгууллаа.

Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмын хүрээнд 2025 оны Увс аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт 1191 шийдвэр, шийтгэх тогтоол, магадлалыг <https://shuukh.mn> сайтад байршуулаад байна.

#### ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ

Увс аймаг дахь шүүхийн тамгын газар нь 2025 онд шүүхийн захиргааны 18, үйлчилгээний 10, нийт 28 ажилтны орон тоогоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 чиглэлээр 76 арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллалаа.

Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжихтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах, хууль хэрэгжиж эхэлснээр Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.

Түүнчлэн, шүүхийн тамгын газраас холбогдох хууль тогтоомж, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан дүрэм, журмыг хэрэгжүүлж ажилласнаар иргэдийн шүүхэд мэдүүлэх эрх, зөрчигдсөн эрхээ сэргээн тогтоолгохоор ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, хүсэлт, гомдол хүлээн авах, хуваарилах ажиллагаа хэвийн тасралтгүй, зөрчилгүй явагдаж, хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах тамгын газрын үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийн гарсан гомдолгүй ажиллав.

Мөн хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр 7 хоног бүр хяналт шалгалт хийж, мэдээлэл бэлтгэн хамт олны шуурхай зөвлөгөөнд танилцуулж хэвшсэн ба ингэснээр анхан болон давж заалдах шатны шүүхийн хэргийн хөдөлгөөний алдаа, зөрчил өмнөх оноос буурч 2025 оны хэргийн хөдөлгөөний удирдлагын цахим хяналт-шинжилгээгээр I улиралд 93.7, II улиралд 95.4, III дугаар улиралд 94.2 хувьтай буюу “Бүрэн хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн.

Хүний нөөцийг чадавхжуулах зорилтын хүрээнд 2025 онд 3 чиглэлийн хүрээнд 13 ажил зохион байгуулахаар төлөвлөж, мэдээлэл технологийн чиглэлээр 4, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 3, эрүү, иргэн захиргааны эрх зүйн бодлого бодох аргачлалын хүрээнд 4, ХАСХОМ гаргахад анхаарах асуудлын талаар 1, шүүхийн захиргааны ажилтны чөлөөт, бүтээлч, бие даасан сэтгэлгээтэй, сурах, ажиллах, амьдрах арга барил олгох зорилгоор 4 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллээр хангах чиглэсэн арга хэмжээний хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг, сумууд болон



Улаангом сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шүүхийн үйл ажиллагаа, шүүгчийн ажлын онцлогийн талаарх сургалтыг зохион байгуулсан.

Шүүхийн тамгын газрын 2025 онд батлагдсан төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу Төрийн хэмнэлтийн хуульд заасан хэмнэлтийг бий болгож ажилласнаар 2024 оны санхүүгийн тайланд аймгийн аудитын газраас зөвлөмжгүй гэсэн дүгнэлтийг гаргасан.

2025 онд шүүгч, ажилтнуудын ажиллах орчин болон иргэд шүүхийн үйлчилгээг ая тухтай орчинд хүргэх зорилгоор шүүхийн байрны 1-3 давхарт их засварын ажлын хүрээнд шүүхийн үйлчилгээний болон шүүхийн хуралдааны танхим, зарим шүүгч, ажилтны өрөөнд засварыг “Мөнхийн ундраа” ХХК хийж гүйцэтгэлээ.

Мөн шүүхийн тамгын газар нь өөрсдийн дотоод нөөцийг ашиглан “шүүх хуралдааны 3 дугаар танхим”, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны хөгжлийг дэмжих зорилгоор “сургалтын танхим”-ыг тус тус шинээр бий болгов.

Батлагдсан төсвийг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн шуудан, харилцаа холбооны зардал, бичиг хэргийн зардал, тээврийн хэрэгслийн болон бусад зардлыг үр ашигтай зарцуулж, өр, авлага үүсгэлгүй ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 53 дугаар “Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай” тогтоолын 2 дугаар хавсралтаар Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоог Ерөнхий шүүгч 1, шүүгч 8, нийт 9 шүүгчийн орон тоотойгоор баталсан байдаг.

Гэтэл 2025 онд Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх нь 5 шүүгчийн орон тоотойгоор ажилласан ба орон тоо дутуугаас шүүгчид ногдох хэргийн тоо эрс нэмэгдсэн. Энэ нь 2025 оны хагас жилийн шүүгчийн зохист ачаалал үзүүлэлтээр харагдаж байх тул 2026 онд 4 шүүгчийн сонгон шалгаруулалтыг зарлаж, сул орон тоог өгөхийг нөхөж уламжилж байна.

Увс аймаг дахь шүүхийн тамгын газар нь 2026 онд шүүхийн цахим шинэчлэл болох “Цахим Шүүх 2.0 систем”-ийн системийн туршилтыг амжилттай нэвтрүүлэх, шүүхийн цахим шинэчлэлд манлайлал үзүүлэн бодит үр дүн гаргах, хэргийн хөдөлгөөний цаашид хэрэгжүүлэх хяналтыг сайжруулж амжилтаа ахиулан ажиллах зорилт тавьж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:  
УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Л.БАТТУЛГА